



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ГАДААДАД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН БА ГАДААДАД ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ, ТЭДГЭЭРИЙН ҮР НӨЛӨӨ

Өрхөд суурилсан судалгааны тайлан

Улаанбаатар хот
2023

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	2
СУДАЛГААНЫ БАГ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	9
ХУРААНГУЙ	10
1 УДИРТГАЛ	12
1.1 Судалгааны үндэслэл	12
1.2 Судалгааны зорилго, ач холбогдол	12
2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	13
2.1 Түүврийн арга зүй	13
2.2 Судалгааны асуулга	15
2.3 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	16
3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН	17
3.1 Гадаадад шилжих хөдөлгөөний “илгээгч” өрхийн шинж байдал	17
3.2 Гадаадад шилжигчдийн шинж байдал	22
3.3 Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрх болон гадаадад шилжигчид хоорондын хувийн шилжүүлэг	28
3.3.1 Өрхийн гадаадад шилжигч гишүүнээс хүлээн авсан гуйвуулга, илгээмж	29
3.3.2 Өрхөөс гадаадад шилжигчдэдээ илгээсэн гуйвуулга, илгээмж	41
3.4 Гадаадад шилжих хөдөлгөөний өрх, нийгэмд үзүүлж буй нөлөө	49
3.5 Гадаадад шилжих хөдөлгөөний цаашдын хандлага, төрөөс анхаарах асуудлууд	53
ДҮГНЭЛТ	60
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	63
ХАВСРАЛТ	64
Хавсралт 1. Хүснэгтүүд	64
Хавсралт 2. "Гадаад улсад амьдарч байгаа гишүүнтэй өрхийн нөхцөл байдал" судалгааны асуулга	83

ӨМНӨХ ҮГ


Үндэсний статистикийн хороо болон Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага хамтран боловсруулсан “Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө” судалгааны тайланг та бүхэнд танилцуулах болсондоо таатай байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.11-д¹ гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийг засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан. Энэхүү ажлын хүрээнд Монгол Улсын төрөөс хилийн чанадад суралцаж, ажиллаж амьдарч байгаа иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эх орондоо эргэн ирэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр нотолгоонд суурилсан шат дараатай бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Дээрх шаардлагад үндэслэн Үндэсний статистикийн хороо нь Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран тус судалгааг хийж, үр дүнг танилцуулж байна.

Судалгаа нь шилжилт хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, цаашид гадаад шилжих хөдөлгөөний үндэсний бодлогыг боловсруулах, стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах суурь судалгаа, статистик мэдээллээр хангах ач холбогдол бүхий, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын зөвлөмжийн дагуу хийгдсэн, гадаад шилжилт хөдөлгөөний асуудлаарх анхны өрхөд суурилсан, үндэсний хэмжээний төлөөлөлтэй түүвэр судалгаа юм.

Судалгаанд гадаад улсад өрхийн гишүүн эсвэл гишүүд нь оршин сууж байгаа өрхүүдийг хамруулж, тэдний нийгэм, хүн ам зүйн шинж байдал, өрхөөс гадаадад илгээсэн иргэдийн шинж байдал болон гадаадад шилжсэн зорилго, шалтгаан, мөнгөн шилжүүлэг, мөнгөн бус илгээмж, гадаад шилжих хөдөлгөөний ойрын ирээдүйн хандлага болон шилжигчдийг буцан ирэх, дасан зохицоход төрийн зүгээс хэрхэн дэмжих талаарх өрхүүдийн санал бодлыг судалсан. Мөн гадаад улсад суугаа Монгол Улсын иргэд эх орон, ар гэрийнхээ амьдралд хэрхэн нөлөөлж буйг Та энэхүү тайлангаас тольдон харах буй за.

ДАРГА



Б.БАТДАВАА

¹ Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
(<https://legalinfo.mn/mn/detail?lawId=211219&showType=1>)

СУДАЛГААНЫ БАГ

ТАЙЛАН ХЯНАСАН:

Б.БАТДАВАА

Санхүүч, Санхүүгийн шинжлэх ухааны магистр

ҮСХ-ны дарга

Ш.АРИУНБОЛД

Эдийн засагч-Статистикч, Хэрэглээний статистикийн магистр

ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Б.МӨНХЖАРГАЛ

Эдийн засагч-Хүн ам зүйч, Социологийн ухааны доктор

МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Нийгмийн ухааны салбар, Антропологи,

археологийн тэнхимийн ахлах багш, Хүн амын сургалт, судалгааны төвийн

судлаач

О.МАНДАХЗОРИГ

Эдийн засагч, Нийгмийн ухааны магистр

ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны

тооллогын хэлтсийн дарга

Б.УРАНБИЛЭГ

Эдийн засагч-Хүн ам зүйч, Бизнесийн удирдлагын магистр

ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны

тооллогын хэлтсийн статистикч

СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД АЖИЛЛАСАН:

С.ДОЛГОРМАА

Эдийн засагч-Санхүүч

ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны

тооллогын хэлтсийн статистикч

Л.ЗУЛЦЭЦЭГ

Эдийн засагч-Статистикч -Хүн ам зүйч, Төрийн бодлого, Хүн ам судлалын
магистр

Судалгааны зохицуулагч

Н.БАЙГАЛМАА

Эдийн засагч, Эдийн засгийн ухааны магистр

Судалгааны гэрээт ажилтан

Э.САРНАЙ

Статистикч

Судалгааны гэрээт ажилтан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХҮРЭЭ, ХУВААРИЛАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР	14
ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНЫ АСУУЛГЫН БҮТЭЦ, АГУУЛГА.....	15
ХҮСНЭГТ 3. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН НИЙТ ӨРХИЙН ХУВЬ, ӨРХИЙН СУУЦНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР	18
ХҮСНЭГТ 4. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ӨРХӨД НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН БАЙГАА ЭСЭХЭЭР, ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР.....	20
ХҮСНЭГТ 5. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, НАС, ХҮЙСЭЭР, ОРШИН СУУЖ БУЙ УЛСААР	24
ХҮСНЭГТ 6. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ТУХАЙН УЛСДАА АМЬДАРСАН ХУГАЦААГААР, ОРШИН СУУЖ БУЙ УЛСААР.....	24
ХҮСНЭГТ 7. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ТУХАЙН УЛСАД ОЧСОН ГОЛ ЗОРИЛГООР, ОРШИН СУУЖ БУЙ УЛСААР	26
ХҮСНЭГТ 8. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХИЙН ХУВЬ, СҮҮЛИЙН 12 САРД ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДЭЭСЭЭ ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН ЭСЭХЭЭР, ӨРХИЙН ШИНЖ БАЙДЛААР	30
ХҮСНЭГТ 9. ИЛГЭЭГЧ ӨРХӨӨС ГАДААДАД ШИЛЖИГЧ 18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН ХУВЬ, МОНГОЛ УЛС ДАХЬ ӨРХДӨӨ ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН БАЙДЛААР, ШИЛЖИГЧИЙН ШИНЖ БАЙДЛААР	31
ХҮСНЭГТ 10. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ*, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР, ШИЛЖИГЧИЙН ОРШИН СУУГАА УЛСААР.....	34
ХҮСНЭГТ 11. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ХҮН АМ, ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРИМ СТАТИСТИК, ШИЛЖҮҮЛГИЙН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, шилжүүлэг хүлээн авагч өрхийн мэдээлэлд суурилсан тооцоогоор.....	35
ХҮСНЭГТ 12. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭГЧИД, ТЭДНЭЭС МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ХҮН АМЫН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН ХЭМЖЭЭ, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, шилжүүлэг илгээгч иргэдийн мэдээлэлд суурилсан тооцоогоор.....	37
ХҮСНЭГТ 13. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) МОНГОЛ УЛСЫН ӨРХҮҮДИЙН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН НИЙТ ХЭМЖЭЭ, САЯ ТӨГРӨГӨӨР, ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, ШИЛЖИГЧДИЙН ОРШИН СУУГАА УЛСААР	38
ХҮСНЭГТ 14. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ӨРХИЙН АМЬЖИРГААНД ШИЛЖҮҮЛГИЙН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨГ ДҮГНЭСЭН БАЙДЛААР.....	40
ХҮСНЭГТ 15. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, СҮҮЛИЙН 12 САРД ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮНДЭЭ ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН ЭСЭХЭЭР, ӨРХИЙН ШИНЖ БАЙДЛААР	42

ХҮСНЭГТ 16. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, МОНГОЛ УЛСАД СУУГАА ӨРХӨӨСӨӨ ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН БАЙДЛААР, ШИЛЖИГЧДИЙН ШИНЖ БАЙДЛААР	43
ХҮСНЭГТ 17. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ*, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР, ШИЛЖИГЧИЙН ОРШИН СУУГАА УЛСААР	45
ХҮСНЭГТ 18. ГАДААДАД ШИЛЖИГЧ ИРГЭДДЭЭ ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ХҮН АМ, ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРИМ СТАТИСТИК, ШИЛЖҮҮЛГИЙН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, шилжүүлэг илгээгч өрхийн мэдээлэлд суурилсан тооцоогоор.	46
ХҮСНЭГТ 19. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ МОНГОЛ УЛСЫН ӨРХҮҮДИЙН ИЛГЭЭСЭН ШИЛЖҮҮЛГИЙН НИЙТ ХЭМЖЭЭ, САЯ ТӨГРӨГӨӨР, ШИЛЖҮҮЛГИЙН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, ШИЛЖИГЧДИЙН ОРШИН СУУГАА УЛСААР	47
ХҮСНЭГТ 20. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУСГАЙЛСАН ХӨТӨЛБӨР ШААРДЛАГАТАЙ ГЭСЭН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ХӨТӨЛБӨРТ ТУСГУУЛАХЫГ ХҮСЭЖ БУЙ АСУУДЛЫГ НЭРЛЭСЭН БАЙДЛААР	54

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. СУДАЛГААНЫ ҮЕ ШАТ	13
ЗУРАГ 2. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН НИЙТ ӨРХИЙН ХУВЬ, АМЬДАРДАГ БАЙРШЛААР	17
ЗУРАГ 3. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН НИЙТ ӨРХИЙН ХУВЬ, АМ БУЛИЙН ТООГООР	18
ЗУРАГ 4. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮД ДЭХ ХҮН АМЫН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЦЭЭР	19
ЗУРАГ 5. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН МОНГОЛ УЛСЫН НИЙТ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР	21
ЗУРАГ 6. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ХЭМЖЭЭ (ТӨГРӨГ), ГАДААД УЛСАД АМЬДАРДАГ ГИШҮҮДИЙН ТООГООР	22
ЗУРАГ 7. ГАДААДАД ШИЛЖИГЧ МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ХУВЬ, ОРШИН СУУГАА УЛСААР	22
ЗУРАГ 8. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ТОО, НАС ХҮЙСИЙН БҮТЦЭЭР.....	23
ЗУРАГ 9. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ТУХАЙН УЛСАД ОЧСОН ГОЛ ЗОРИЛГООР	25
ЗУРАГ 10. 16, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ШИЛЖИЛТЭЭС ӨМНӨХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР, ХҮЙСЭЭР	27
ЗУРАГ 11. ГАДААД УЛСАД ЯВАХААС ӨМНӨ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙСАН ГАДААДАД ШИЛЖИГЧИД (15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ)-ИЙН ХУВЬ, ЭРХЭЛЖ БАЙСАН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛБЭРЭЭР, ХҮЙСЭЭР.....	28
ЗУРАГ 12. СҮҮЛИЙН 12 САРД МОНГОЛ УЛСАД СУУГАА ӨРХДӨӨ МӨНГӨН ГУЙВУУЛГА ИЛГЭЭСЭН ГАДААД УЛСАД ОРШИН СУУЖ БУЙ 18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН ХУВЬ, ГУЙВУУЛГА ИЛГЭЭСЭН ДАВТАМЖААР, ХҮЙСЭЭР	32
ЗУРАГ 13. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН ГУЙВУУЛГА ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ГУЙВУУЛГА ХҮЛЭЭН АВАХДАА АШИГЛАСАН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР.....	33
ЗУРАГ 14. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР*.....	33
ЗУРАГ 15. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВАХАД БЭРХШЭЭЛ ТУЛГАРСАН БАЙДЛААР	35
ЗУРАГ 16. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ӨРХҮҮДИЙН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ТӨГРӨГ), ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭГЧИЙН ШИНЖ БАЙДЛААР.....	39

ЗУРАГ 17. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ӨРХҮҮДИЙН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН ТОХИОЛДЛУУД, ЗАРЦУУЛАГДСАН БАЙДЛААР.....	39
ЗУРАГ 18. СҮҮЛИЙН 12 САРД МОНГОЛ УЛСАД СУУГАА ӨРХӨӨСӨӨ МӨНГӨН ГУЙВУУЛГА ХҮЛЭЭН АВСАН ГАДААДАД ШИЛЖИГЧ ИРГЭДИЙН ХУВЬ, ГУЙВУУЛГА АВСАН ДАВТАМЖААР, ХҮЙСЭЭР	44
ЗУРАГ 19. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН ГУЙВУУЛГА ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ГУЙВУУЛГА ИЛГЭЭХДЭЭ АШИГЛАСАН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР	44
ЗУРАГ 20. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР*	45
ЗУРАГ 21. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭХЭД БЭРХШЭЭЛ ТУЛГАРСАН БАЙДЛААР ..	46
ЗУРАГ 22. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ИЛГЭЭСЭН ШИЛЖҮҮЛГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ТӨГРӨГ), ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВАГЧИЙН ШИНЖ БАЙДЛААР	48
ЗУРАГ 23. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ СҮҮЛИЙН 12 САРД ӨРХӨӨС ШИЛЖҮҮЛСЭН ШИЛЖҮҮЛГИЙН ТОХИОЛДЛУУД, ХҮЛЭЭН АВАГЧИД НЬ ШИЛЖҮҮЛГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙДЛААР	49
ЗУРАГ 24. ӨРХИЙН ГИШҮҮНЭЭ ГАДААД УЛСАД ИЛГЭЭСНЭЭР АМЬДРАЛД НЬ ЯМАР НЭГ НӨЛӨӨ ГАРСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ЭЕРЭГ НӨЛӨӨГ НЭРЛЭСЭН БАЙДЛААР	50
ЗУРАГ 25. ӨРХИЙН ГИШҮҮНЭЭ ГАДААД УЛСАД ИЛГЭЭСНЭЭР АМЬДРАЛД НЬ ЯМАР НЭГ НӨЛӨӨ ГАРСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, СӨРӨГ НӨЛӨӨГ НЭРЛЭСЭН БАЙДЛААР	51
ЗУРАГ 26. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ИРГЭДИЙН ГАДААДАД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ДҮГНЭСЭН БАЙДЛААР	52
ЗУРАГ 27. ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ГАДААД УЛС РУУ ЯВСАН ИРГЭДИЙГ ЭХ ОРОНДОО БУЦАН ИРЭХЭД ТӨР ЗАСГААС НЭН ТЭРГҮҮНД ШИЙДВЭРЛЭЭСЭЙ ГЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛААР	57
ЗУРАГ 28. ИРЭХ 12 САРЫН ХУГАЦААНД ӨРХИЙН ГИШҮҮН НЬ ГАДААД УЛС РУУ 6-ААС ДЭЭШ САРААР ШИЛЖИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ШИЛЖИЛТИЙН ЗОРИЛГООР	58
ЗУРАГ 29. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ИРЭХ 12 САРЫН ХУГАЦААНД ӨРХИЙН ГИШҮҮН НЬ ГАДААД УЛС РУУ 6+ САРААР ШИЛЖИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ЭСЭХЭЭР, ӨРХИЙН ШИНЖ БАЙДЛААР	59

НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт
Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ.
Гадаадад шилжигч	Гадаад улсад 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийг хамруулж ойлгоно. Мөн хэдийгээр 6 сар (183 хоног) хүрээгүй боловч цаашид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар гадаадад оршин суухаар төлөвлөж буй иргэдийг хамруулна.
Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрх	Гадаад улсад 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа гишүүнтэй буюу гадаадад шилжигчтэй өрхийг ойлгоно.
Хувийн шилжүүлэг	Гадаадад оршин сууж буй иргэд ба Монгол Улсад оршин сууж буй өрхийн гишүүд хооронд хийгдсэн мөнгөн гуйвуулга, түүнчлэн эд зүйлсийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн тооцсон мөнгөн дүнг ойлгоно.
Өрхийн орлого	Өрхийн орлого нь өрхийн болон гэр бүлийн гишүүдээс жил бүр эсвэл илүү давтамжтайгаар хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус зүйл (бараа, үйлчилгээ) -ийг хүлээн авсан бүх орлогоос бүрдэнэ. Өрхийн орлогыг дараах байдлаар тодорхойлж болно: (i) хөдөлмөр эрхлэлтийн орлого (цалин хөлс, хувиараа хөдөлмөр эрхэлдэг); (ii) өмчийн орлого; (iii) өөрийн хэрэглээнд зориулж өрхийн үйлчилгээг үйлдвэрлэлээс олох орлого; ба (iv) хүлээн авсан шилжүүлэг.
Хөдөлмөр эрхлэлтийн статус ²	Хөдөлмөр эрхлэлтийн статус гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдыг тухайн эдийн засгийн нэгж дэх эрх мэдлийн байдлыг харгалзан ангилахыг ойлгоно.

² Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, ҮСХ, ХНХЯ, 2019 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХЯ	Гадаад Харилцааны Яам
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ИБУИНВУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОУШХБ	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СЯ	Сангийн Яам
ТББ	Төрийн Бус Байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮАМАТ	Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ШВУ	Шведийн Вант Улс
ЭЗБТУАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ЭЗХЯ	Эдийн Засгийн Хөгжлийн Яам

ХУРААНГУЙ

Шилжих хөдөлгөөн нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөд шууд нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг юм. Шилжих хөдөлгөөнийг нарийвчлан судлах нь хүн амын байршил тархалт, нөөцийн хуваарилалт, нийгэм, эдийн засгийн төлөвлөлт зэрэгт чухал нөлөөтэй бөгөөд шилжих хөдөлгөөнийг оновчтой удирдан зохицуулах бодлого, хөтөлбөр боловсруулахад үндэс суурь нь болох учиртай.

Судалгаа нь Монгол Улсын иргэдийн гадаад шилжих хөдөлгөөний асуудлаар анхны өрхөд суурилсан, үндэсний хэмжээний судалгаа юм. Судалгаагаар дараах үр дүнгүүд гарлаа. Үүнд:

- Монгол Улсын нийт өрхийн 6.1 хувь (57896 өрх) гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрх буюу өрхийн аль нэг гишүүн нь 6, түүнээс дээш сараар гадаад улсад оршин сууж байгаа өрхүүд байна. Эдгээр илгээгч өрхүүдэд нийт 186321 хүн амьдарч байгааг насны бүтцээр авч үзвэл, ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдүүдээс гадна 50-аас дээш насны иргэд нэлээд байгаа нь онцлог харагдаж байна. Илгээгч өрхийн орлогын гол эх үүсвэр нь цалин хөлс (50.5 хувь), тэтгэвэр, тэтгэмж (65.3 хувь), сарын дундаж орлого нь 1.5 сая төгрөг, сарын дундаж зардал нь 1.1 сая төгрөг, 41.0 хувь нь хөдөлмөр эрхэлдэг гишүүнгүй байна.
- Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч 57896 өрхөөс 106534 иргэн (цаашид гадаадад шилжигчид гэх) ихэвчлэн ажиллах (44.3 хувь), суралцах (35.9 хувь)-аар гадаад улсыг зорьсон байна. Эдгээр иргэдийн 53.9 хувь эмэгтэй, 40.8 хувь 20-34 насныхан, дунджаар 7.2 жил гадаад улсад амьдарч байгаа аж. Гадаадад шилжигчдийн 30.7 хувь нь БНСУ, 12.3 хувь нь АНУ, 9.9 хувь нь Япон улс, 6.9 хувь нь БНЧУ, 5.7 хувь нь ШВУ, 34.4 хувь нь дэлхийн бусад улс орнуудад амьдарч байна.
- Сүүлийн 12 сарын хугацаанд 22622 илгээгч өрх (нийт илгээгч өрхийн 39.1 хувь) 18, түүнээс дээш насны гадаадад шилжигчдээсээ 149.0 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулга ба мөнгөн бус эд зүйлс, эсхүл тэдгээрийн аль нэгийг буюу хувийн шилжүүлэг хүлээн авчээ. Хүлээн авсан хувийн шилжүүлгийн 124.2 тэрбум нь мөнгөн гуйвуулга хэлбэрээр, 24.8 тэрбум нь удаан эдэлгээтэй бараа болон өдөр тутмын хэрэглээний түргэн эдэлгээтэй бараануудаас бүрдсэн илгээмж хэлбэрээр өрхүүдэд очсон байна.
- Мөнгөн гуйвуулга хүлээн авсан тохиолдлуудын 82.3 хувь нь өрхийн өдөр тутмын хэрэгцээгээ хангахад дэм болон зарцуулагдсанаас гадна давхардсан тоогоор, 47.3 хувь нь эрүүл мэнд, боловсрол зэрэг хүмүүн капиталд хөрөнгө оруулахад, 11.1 хувь нь өрхийн өр зээлийг барагдуулахад, 4.3 хувь нь байр, сууц, газар зэрэг удаан эдэлгээтэй өмч хөрөнгө худалдан авахад, 3 хувь нь хадгалахад, 2.6 хувь нь

өрхийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хөрөнгө оруулалт болгон ашиглагдсан байна. Гуйвуулга, илгээмж хүлээн авагч өрхүүдийн дийлэнх нь (95.8 хувь нь) гадаадад шилжигчдийн илгээсэн шилжүүлэг өрхийн амьжиргаанд нь эерэг нөлөө үзүүлсэн гэж хариулсан байна.

- Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 26.7 хувь (15435 өрх) нь сүүлийн 12 сард гадаад улсад байгаа 26373 гишүүндээ 54.1 тэрбум төгрөгийн хувийн шилжүүлэг илгээсэн байна. Илгээсэн шилжүүлгийн 45.2 тэрбум нь мөнгөн гуйвуулга хэлбэрээр, 8.9 тэрбум нь илгээмж байна. Өрхөөс илгээсэн мөнгөн гуйвуулга нь ихэвчлэн өдөр тутмын хэрэглээ, сургалтын төлбөр, байрны зардал зэрэгт зориулагдсан байгаа нь Монгол Улсаас гадаадад гарч буй хувийн шилжүүлэг ихэвчлэн боловсрол эзэмших зорилготой шилжигчид рүү чиглэсэн болохыг илтгэж байна. Харин илгээмжийн хувьд дийлэнх нь хүнсний зүйлээс бүрдсэн байв.
- Гадаадад шилжигчдийн ар гэр, хувийн амьдралд нь шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор эерэг болон сөрөг өөрчлөлтийн аль аль нь гарсан ч эерэг өөрчлөлт, нөлөөг нэрлэсэн өрхийн тоо (9.1 хувь) сөрөг нөлөөг нэрлэсэн өрхөөс (8.4 хувь) олон байна. Гадаадад өрхийн гишүүн нь амьдарснаар өрхийн амьдралд өөрчлөлт орсон гэж үзэж буй өрхүүдийн давхардсан тоогоор 76 хувь нь өрхийн хүмүүн капиталд, 62 хувь нь өрхийн ахуйн нөхцөл, амьдрах орчинд эерэг нөлөө гарсан гэж үзсэн байхад, 61.9 хувь нь гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжилд, 29.3 хувь нь өрхийн гишүүний эрүүл мэнд, өрхийн санхүү, ахуй соёлоо хадгалах зэрэг асуудалд сөргөөр нөлөөлсөн гэж хариулсан байна.
- Гадаадад шилжигчдийг буцаж ирэхэд төр засгийн зүгээс шийдээсэй гэсэн асуудлын дийлэнх нь эдийн засгийн асуудал байна. Тухайлбал, илгээгч өрхийн 65.1 хувь нь гадаадад шилжигчдийг буцаж ирэхэд ажлын байраар хангах, 29.2 хувь нь улс орны эдийн засгийг тогтвортой байлгах, 24.7 хувь нь бизнес эрхлэх боломжуудыг нэмэгдүүлэх болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлттэй болгож, гаалийн татвар, хураамжийг багасгах, 15.2 хувь нь бизнесийн болон орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхийг санал болгосон байна. Мөн зарим өрхүүд эрүүл мэнд, боловсрол, бусад нийгмийн үйлчилгээг илүү боловсронгуй болгох (26.5 хувь), улс төрийг тогтвортой байлгах (14.1 хувь) нь ч шилжигчдийг буцаж ирэхэд чухал гэж үзсэн байна.
- Шилжих хөдөлгөөний илгээгч дөрвөн өрх тутмын нэг нь ирэх нэг жилийн хугацаанд гадаад улсад нэмж өөр гишүүнээ явуулахаар төлөвлөж байна. Ирээдүйн шилжилтийн зорилгыг асуухад гурван өрх тутмын нэг нь ажил эрхлэлттэй холбоотой, таван өрх тутмын нэг нь гадаадад байгаа гэр бүлийн гишүүнтэй хамт байх, нэгдэх, мөн таван өрх тутмын нэг нь боловсрол эзэмшихтэй холбоотой зорилгыг нэрлэсэн байна.

1. УДИРТГАЛ

1.1. Судалгааны үндэслэл

Дэлхийн нийгэм, эдийн засаг хийгээд хүн ам зүйн шилжилт, өөрчлөлт, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход улс, бүс дамнасан гадаад шилжих хөдөлгөөний цар хүрээ, шинж байдлыг судлах нь чухал юм. Сүүлийн тавин жилийн хугацаанд олон улсын шилжилт хөдөлгөөнд оролцогчид өссөөр, 2020 онд 281 сая хүрсэн нь дэлхийн хүн амын 3.6 хувьтай тэнцэж байна. Энэ нь 1990 оны түвшнээс 128 саяар, харин 1970 оны түвшнээс 3 дахин нэмэгджээ³.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнгээр 122.3 мянган иргэн гадаадад оршин сууж байгаа нь 2010 оны тооллогоос 14.2 хувиар өссөнөөс гадна гадаад шилжих хөдөлгөөнд оролцсон Монгол Улсын иргэдийн гуравны нэг нь суралцах, гуравны нэг нь ажиллах, үлдсэн хувь нь бусад зорилгоор гадаад улсад амьдарч байна.

Монгол Улс нь гадаад шилжих хөдөлгөөний статистик мэдээллийн хувьд урсгал (migration flow)-ыг харуулах захиргааны эх үүсвэр (хилээр орсон гарсан иргэдийн мэдээ)-тэй, тогтмол давтамжтайгаар гаргадаг бол гадаадад шилжин суурьшигчид (migration stock)-ын тоо мэдээллийг 10 жилд нэг удаа явагддаг хүн ам, орон сууцны тооллогоор гаргаж байна (Мөнхжаргал, Б. 2022).

Гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр хүн ам, эдийн засаг, нийгэмд эерэг, сөрөг үр дагаврууд үүсдэг учраас үндэсний түвшний бодлого, хөтөлбөрт гадаад шилжих хөдөлгөөний өөрчлөлтөд хариу үзүүлэх, өөрийн орны онцлогт тохирсон бодлогыг тодорхойлох, боловсруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудал чухлаар тавигддаг. Хэдийгээр хүн ам, орон сууцны тооллого нь хөгжлийн үр дүнтэй төлөвлөлт, шийдвэр гаргахад үндсэн мэдээллийн эх үүсвэр болдог ч гадаад шилжих хөдөлгөөний чиг хандлага, илгээгч өрхийн аж, амьдралд үзүүлэх өөрчлөлт, тулгарч буй бэрхшээл, анхаарах асуудал зэргийг цогцоор нь судлан, бодлогын хэрэгцээ, шаардлагыг хангахуйц нарийн тодорхой мэдээлэл болж чадахгүй байна.

1.2. Судалгааны зорилго, ач холбогдол

Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний ерөнхий дүр зураг, гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн өрхийн аж байдалд үзүүлж буй зарим үр нөлөөг шилжигчдээ “илгээгч өрх”-ийн мэдээлэлд үндэслэн судлах явдал юм. Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

³ Дэлхийн шилжих хөдөлгөөний тайлан, НҮБ-ОУШХБ, 2022 он

- (i) Илгээгч өрхийн шинж байдлыг тодорхойлох;
- (ii) Гадаадад шилжигчдийн тоо хэмжээ, шинж байдлыг тогтоох;
- (iii) Гадаадад шилжигчид болон тэдний Монгол Улсад суугаа өрх хоорондын шилжүүлэг, гуйвуулгын талаар судлах;
- (iv) Гадаадад шилжигчдийн “илгээгч өрх”-д үзүүлж буй нөлөөг судлах;
- (v) Гадаадад шилжих хөдөлгөөний цаашдын хандлага, төрөөс анхаарах асуудлуудыг тодорхойлох зэрэг зорилтууд багтсан.

Тус судалгааг хийснээр, гадаад шилжих хөдөлгөөний талаар төрөөс баримтлах бодлогод чиглэсэн санал зөвлөмж, үндэсний хөтөлбөр боловсруулахад шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, тоон мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Монгол Улсын нийт өрхөөс хэн нэг гишүүн/гишүүд нь 6, түүнээс дээш сараар гадаад улсад амьдарч байгаа өрхийг судалгааны нэгж гэж үзэн түүврийн хүрээ бүрдүүлж, магадлалт түүврийн аргаар түүврийн олонлог бүрдүүлэн, урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу судалгааны мэдээллийг цуглуулж, боловсруулсан. Судалгааны үе шатыг ЗУРАГ 1-д харуулав.

ЗУРАГ 1. СУДАЛГААНЫ ҮЕ ШАТ



2.1. Түүврийн арга зүй

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж өрх бөгөөд өрхийн аль нэг гишүүн/гишүүд нь гадаад улсад амьдарч байгаа өрхийн нийт тоо уг судалгааны хүрээг бүрдүүлсэн (ХҮСНЭГТ 1). ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй нийт өрхөөс 2023 оны 3-р сарын байдлаар 57912 өрхийн аль нэг гишүүн нь гадаад улсад ажиллаж, амьдарч байна. Судалгааны түүврийн хэмжээг үндэсний хэмжээнд төлөөлөхүйц байхаар дараах томъёоллын дагуу тооцон, түүврийн нийт хэмжээг 2204 өрх байхаар тодорхойлсон.

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} * rr$$

z- зорилтот ач холбогдлын түвшнийг тодорхойлсон статистик утга (95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга=1.96);

P₀ – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин (утга=0.50);

e – алдааны хязгаар (таамагласан харьцангуй алдаа=5 %, абсолют алдаа 0.016);

rr – асуулгад хариулахгүй байх байдлыг засварлагч (судалгаанд 10 хүн тутмын гурав нь буюу 30 хувь нь ямар нэгэн шалтгаанаар хариулахгүй байна гэж үзсэн).

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХҮРЭЭ, ХУВААРИЛАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

№	Аймаг	Өрхийн тоо	Түүврийн хэмжээ	ТАШН-ийн дугаар (PSU)
1	Баян-Өлгий	2 119	76	1
2	Говь-Алтай	213	76	2
3	Завхан	333	76	3
4	Увс	278	76	4
5	Ховд	761	76	5
6	Архангай	445	76	6
7	Баянхонгор	419	76	7
8	Булган	483	76	8
9	Орхон	2 036	76	9
10	Өвөрхангай	668	76	10
11	Хөвсгөл	562	76	11
12	Говьсүмбэр	322	76	12
13	Дархан-Уул	2 777	76	13
14	Дорноговь	813	76	14
15	Дундговь	278	76	15
16	Өмнөговь	340	76	16
17	Сэлэнгэ	1 489	76	17
18	Төв	1 190	76	18
19	Дорнод	536	76	19
20	Сүхбаатар	262	76	20
21	Хэнтий	486	76	21
22	Улаанбаатар	41 102	608	
	НИЙТ	57 912	2 204	-

Судалгааны түүвэр нь нэг үе шаттай, түүврийн анхан шатны нэгж нь 21 аймаг, 8 дүүрэг бөгөөд нийт 29 нэгжтэй, нэгжид ногдох өрхийн тоог тэгш хуваарилалтын арга ашиглан 76 өрх байхаар тодорхойлсноос гадна 76 өрхийг сонгохдоо системчилсэн магадлалт түүврийн аргыг ашигласан. Түүврийн хамралтын үр дүнг дүгнэвэл, төлөвлөсөн түүврийн 99.3 хувь нь судалгаанд бүрэн гүйцэт хариулт өгч, эх олонлогийн дүнгээр 57896 гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийг төлөөлж байна.

2.2. Судалгааны асуулга

Судалгааны асуулгыг боловсруулахдаа Монгол Улсад баримталж байгаа бодлого, хөтөлбөрийн зорилго, зорилт, НҮБ-ын Шилжих хөдөлгөөний шинжээчдийн бүлгээс боловсруулсан олон улсын шилжих хөдөлгөөний стандарт асуулгын зөвлөмж болон 2015 онд ХНХЯ-ны захиалгаар Хүний хөгжил судалгаа, сургалтын төвийн зохион байгуулсан судалгааны асуулга зэрэгт үндэслэсэн болно. Өрхөд суурилсан түүвэр судалгааны асуулга дараах үндсэн 4 бүлэг бүхий 46 асуултаас бүрдсэн (ХҮСНЭГТ 2). Үүнд:

ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНЫ АСУУЛГЫН БҮТЭЦ, АГУУЛГА

№	Бүлгийн нэр, асуулгын дугаар	Бүлгийн ерөнхий агуулга	Хүлээгдэж буй үр дүн
1	Өрхийн шинж байдал (Н1-Н10)	Тухайн өрхийн ам бүл, гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн сууцны төрөл, эзэмшил, орон сууцны зээл, өрхийн сарын дундаж орлого, зарлагын тухай асуултууд багтсан.	Өрхийн гишүүн/гишүүд нь гадаад улсад амьдарч буй өрхүүдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдал, дүр зургийг харуулна.
2	Өрхөөс гадаад улсад амьдарч байгаа гишүүд (М1-М8)	Өрхөөс хэдэн гишүүн гадаадад оршин суугаа, тэдний нас, хүйс, шилжихээс өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, аль улсад шилжсэн, тухайн улсад очсон зорилго, амьдарч байгаа хугацаа зэрэг асуултууд багтсан.	Гадаад улсад оршин сууж буй Монгол Улсын иргэдийн ерөнхий шинж байдлын мэдээллийг харуулна.
3	Мөнгөн болон мөнгөн бус гуйвуулга (I1-I9, O1-O7)	Гадаад улсад байгаа гишүүнээс өрх мөнгөн гуйвуулга ба мөнгөн бус илгээмж хүлээн авдаг байдал, хэмжээ, тэдгээрийн зарцуулалт, үр нөлөө; өрхөөс гадаадад байгаа гишүүндээ мөнгөн гуйвуулга, илгээмж явуулдаг байдал, хэмжээ, зарцуулалт зэрэг асуултууд багтсан.	Гадаад улсад оршин суугаа иргэд болон тэдний Монгол Улсад суугаа ар гэрийнхэн хооронд сүүлийн нэг жилд хийгдсэн хувийн шилжүүлэг, түүний хэмжээ, хэрэглээ, ач холбогдлын тухай мэдээллийг харуулна.
4	Санал бодол (P1-P8)	Гадаадад шилжигчээ илгээснээр өрхийн амьдралд гарч буй өөрчлөлтүүд, өрхийн гадаад шилжих хөдөлгөөнд оролцох ирээдүйн төлөвлөгөө, гадаадад шилжигчдийн буцаж ирэхийг дэмжих чиглэлээр төрөөс хийгээсэй гэж хүсэж буй асуудал зэрэг асуултууд багтсан.	Өрхийн гишүүн гадаад улсад амьдрах нь гадаад шилжих хөдөлгөөний "илгээгч" өрхүүдэд ямар зэрэг, сөрөг нөлөө үзүүлж буй, цаашид гадаадад шилжигчдийн буцаж ирэхийг дэмжих чиглэлээр төрийн дэмжлэг шаардлагатай байгаа асуудлуудын талаарх мэдээллийг харуулна.

2.3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 5-6 сард хийж гүйцэтгэсэн. Илгээгч өрхөөс CATI (Computer Assisted Telephone Interview – Компьютерт суурилсан утасны ярилцлагын арга) буюу ухаалаг төхөөрөмж ашиглаж, судалгаанд оролцогчтой утсаар ярилцах аргаар судалгааны мэдээллийг цуглуулсан. Мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл явц дараах шатлалаар явагдсан. Үүнд:

- Нэгдүгээрт, Kobo программд таблетад суурилуулах асуулгын эх загварыг бэлтгэж, таблетад суурилуулсан;
- Хоёрдугаарт, мэдээлэл цуглуулагч асуулгын дагуу хариулагчаас ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан;
- Гуравдугаарт, цуглуулсан мэдээллийг утасгүй интернэтийн сүлжээгээр дамжуулан төв систем рүү илгээсэн;
- Дөрөвдүгээрт, цуглуулсан мэдээлэл нэгтгэсэн,
- Тавдугаарт, мэдээлэл цуглуулагчдын явуулсан мэдээллийг дор бүр нь шалгаж мэдээллийн чанарын хяналтыг хийсэн;
- Зургаадугаарт, цуглуулсан нийт мэдээлэлд анхдагч болон хоёрдогч боловсруулалт хийж судалгааны үр дүнг боловсруулсан.

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


3.1. Гадаадад шилжих хөдөлгөөний “илгээгч” өрхийн шинж байдал

Энэхүү бүлэгт гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн онцлогийг тэдний хүн ам зүйн шинж байдал, ахуйн нөхцөл, амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдээр судлан харуулав.

Монгол Улсын нийт өрхийн 6.1 хувь буюу 57896 өрх гадаадад өрхийн нэг болон түүнээс дээш тооны гишүүдээ илгээсэн байна. Өөрөөр хэлбэл, эдгээр өрх бүрээс нэг, эсхүл түүнээс олон тооны гишүүн гадаад улсад б, түүнээс дээш сараар оршин суухаар явсан байна.

Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийг байршлаар авч үзвэл, 71.0 хувь нь нийслэл хотод, 19.4 хувь нь аймгийн төвд, 5.5 хувь нь сумын төвд, 4.1 хувь нь хөдөөд амьдардаг өрхүүд байна (ЗУРАГ 2). Илгээгч өрхүүд ихэвчлэн мэдээлэл холбоо, зам харилцаа сайтай, хүн ам ихтэй, суурин газрын өрхүүд байгаа нь гадаад шилжих хөдөлгөөний идэвх, түвшинг тайлбарладаг онолуудтай нийцтэй үр дүн байв.


ЗУРАГ 2. ГАДААДАД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН НИЙТ ӨРХИЙН ХУВЬ, АМЬДАРДАГ БАЙРШЛААР



*ҮСХ. 2022 оны Монгол Улсын өрхийн тоо

Илгээгч өрхүүдийн ам бүлийн дундаж хэмжээ 3.2 байгаа нь улсын дунджаас бага байгаа ч ам бүлийн тооны медиан үзүүлэлт нь улсын дундажтай ойролцоо байна. Тухайлбал, илгээгч өрхийн тал хувь нь одоогоор 4 хүртэл тооны ам бүлтэй, үлдсэн тал хувь нь 4-өөс олон ам бүлтэй амьдарч байв. Өрхийн 42.4 хувь 1-2 ам бүлтэй, 33.7 хувь 3-4 ам бүлтэй, 23.9 хувь 5, түүнээс олон ам бүлтэйгээр амьдарч байгаа нь улсын дундажтай харьцуулахад арай цомхон бүтэцтэй байгааг харуулж байна (ЗУРАГ 3).

ЗУРАГ 3. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН НИЙТ ӨРХИЙН ХУВЬ, АМ БҮЛИЙН ТООГООР



Жилийн дөрвөн улиралтай, халуун ба хүйтний улирлууд нь эрс тэс цаг уурын нөхцөлтэй Монгол Улсын хувьд өрх төвлөрсөн ус, дулаан, цахилгаан хангамж, ариун цэврийн байгууламжид холбогдсон орон сууц, эсхүл ус, дулаан, ариун цэврийн байгууламжаа орчин үеийн инженерийн шийдлээр шийдсэн бие даасан тохилог сууцанд амьдрах нь тухайн өрхийн ахуйн нөхцөл харьцангуй тав тухтай байгааг илтгэдэг. Судалгааны дүнгээр, илгээгч өрхүүдийн амьдарч буй ахуйн нөхцөлийн байдал улсын дунджаас харьцангуй сайн байгаа үр дүн гарлаа (ХҮСНЭГТ 3).

ХҮСНЭГТ 3. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН НИЙТ ӨРХИЙН ХУВЬ, ӨРХИЙН СУУЦНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР


Өрхийн сууцны үзүүлэлтүүд	Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд	Монгол Улсын өрх (2020 оны ХАОСТ-оор)
Амьдарч буй сууцны төрөл:		
Гэрт	10.4	38.2
Орон сууцны байшинд	55.0	29.4
Бие даасан тохилог сууцанд	2.9	0.7
Сууцны тусдаа байшинд	26.4	29.9
Нийтийн байранд	0.6	0.9
Бусад сууц	4.7	0.9
Амьдарч буй сууцны эзэмшлийн байдал:		
Өөрийн эзэмшлийн	88.9	94.7
Бусдын сууцанд түрээстэй	5.1	1.6
Бусдын сууцанд түрээсгүй	4.7	3.6
Бусад	1.3	0.1
Орон сууцны зээлтэй эсэх:		
Тийм	13.3	-
Үгүй	86.7	-
Бүгд	100.0	100.0
Өрхийн тоо	57 896	897 427

Тодруулбал, өрхийн гишүүн нь гадаад улсад амьдарч буй өрхүүдийн 55.0 хувь нь орон сууцны байшинд, 2.9 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 2-4 дахин өндөр байв. Харин гэр сууц, төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй сууцны тусдаа байшин буюу хашаа байшин, нийтийн байр зэрэг сууцанд амьдрах байдал улсын дунджаар гурван өрх тутмын хоёрт тохиолддог байхад, өрхийн гишүүн нь гадаадад байгаа өрхүүдийн хувьд гурван өрх тутмын нэгд нь тохиолдож байна.

Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд өөрийн эзэмшлийн өмч хөрөнгө буюу сууцтай байгаа эсэх, үл хөдлөх хөрөнгийн урт хугацааны зээлтэй эсэхийг судалж үзэхэд, дийлэнх (88.9 хувь) нь өөрийн эзэмшлийн сууцтай, 13.3 хувь нь өөрийн өмчлөлийн орон сууцтай болохоор орон сууцны зээлд хамрагдсан байна.

Шилжих хөдөлгөөний илгээгч 57896 өрхөд 2023 оны байдлаар нийт 186321 иргэн амьдарч байна (ЗУРАГ 4). Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдэд амьдарч байгаа хүн амын 48.4 хувь эмэгтэйчүүд, 51.6 хувь эрэгтэйчүүд байгаа нь хүйсийн тэнцвэртэй байдал алдагдаагүйг харуулах ч улсын дундаж үзүүлэлт (эрэгтэй 49.3 хувь, эмэгтэй 50.7 хувь)-тэй харьцуулахад илгээгч өрхүүдэд үлдсэн хүн ам дунд эмэгтэйчүүдийн хувь арай бага байна. Илгээгч өрхөд ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдүүд болон 60-аас дээш насны иргэдийн хувийн жин өндөр байх хандлагатай байна.

ЗУРАГ 4. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮД ДЭХ ХҮН АМЫН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЦЭЭР



Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн 41.0 хувьд нь шилжигчдийн эзгүйд хөдөлмөр эрхэлдэг гишүүн байхгүй, харин 59.0 хувьд нь 1, түүнээс олон тооны хөдөлмөр эрхэлдэг хүн байна (ХҮСНЭГТ 4). Хөдөлмөр эрхэлдэг гишүүдтэй өрхүүдэд хамгийн ихдээ 5 хүн хөдөлмөр эрхэлж буй тохиолдол байсан ба нэг өрхөд дунджаар 1.5 хөдөлмөр эрхлэгч байна.

ХҮСНЭГТ 4. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ӨРХӨД НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН БАЙГАА ЭСЭХЭЭР, ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР


Өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлын үзүүлэлтүүд		Дүнд эзлэх хувь
Шилжигчийн эзгүйд өрхөд хөдөлмөр эрхэлдэг гишүүн үлдсэн эсэх		
Тийм		59.0
Үүнээс:	Нэг хүн хөдөлмөр эрхэлдэг	(35.7)
	2 хүн хөдөлмөр эрхэлдэг	(19.2)
	3, түүнээс олон хүн хөдөлмөр эрхэлдэг	(4.1)
Үгүй		41.0
Бүгд		100.0
Илгээгч өрхийн тоо		57 896
Хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй өрх дэх хөдөлмөр эрхлэгчдийн тооны статистик үзүүлэлтүүд		
Хамгийн цөөн		1
Хамгийн олон		5
Нэг өрх дэх хөдөлмөр эрхэлдэг хүний дундаж тоо		1.5
Медиан		1.0
Хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй илгээгч өрхийн тоо		34 141
Хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн статус *		
Цалинтай ажиллагч		79.9
Бие даасан ажиллагч		21.4
Ажил олгогч		4.8
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн		5.4
Бусад		1.0
Хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн тоо		34 141

Тайлбар: *хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй өрхүүдээс хөдөлмөр эрхлэлтийн статус тус бүрээр ажилладаг хүн байгаа эсэхийг асуусан. Хэрэв нэг өрхөд 1-ээс олон хөдөлмөр эрхэлдэг гишүүн байгаа бол, уг асуултад олон хариулт авсан тул хариултын нийлбэр 100%-иас илүү байна.

Хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй илгээгч өрхийн давхардсан тоогоор 79.9 хувь нь цалин, хөлстэй ажил эрхэлдэг гишүүнтэй, 21.4 хувь нь бие даасан ажиллагч гишүүнтэй, 4.8 хувь нь ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч гишүүнтэй, 5.4 хувь нь өрхийн бизнес, аж ахуйд хувь нэмрээ оруулагч гишүүнтэй байна.

Судалгаагаар гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн орлогын эх үүсвэрүүд, орлого, зарлагын ерөнхий мэдээллийг цуглуулсан ба орлогын эх үүсвэрийн талаарх үр дүнг ҮСХ-ны ӨНЭЗС-2022 судалгааны үр дүнтэй харьцуулан ЗУРАГ 5-д, орлого, зарлагын хэмжээний талаарх ерөнхий статистикийг ЗУРАГ 6-д харуулав.

ЗУРАГ 5. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХ БОЛОН МОНГОЛ УЛСЫН НИЙТ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР




*ҮСХ-ны ӨНЭЗС-2022 судалгааны үр дүн.

Өрхийн орлогын эх үүсвэрийг олон сонголттойгоор асуусан тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Илгээгч өрхүүд дунд давхардсан тоогоор, цалин хөлсний орлоготой өрх 50.5 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрх 65.3 хувь, ХАА-н үйлдвэрлэлийн орлоготой өрх 5.0 хувь, ХАА болон түрээсийн үйл ажиллагаанаас бусад төрлийн бизнесийн орлоготой өрх 3.8 хувь, хувийн шилжүүлгийн орлоготой өрх 3.6 хувь байв. Эдгээр үр дүнг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнтэй харьцуулахад, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эх үүсвэртэй байдал улсын дунджаас 2.5 дахин өндөр, ХАА-н болон ХАА-н бус бизнесийн орлоготой байдал 1.7 дахин бага байна. Өөрөөр хэлбэл, тухайн өрхүүдээс ихэнхдээ хөдөлмөрийн насны иргэд гадаад улс руу шилжин явж, тэтгэвэр тэтгэмжээс хамааралтай хүн ам үлдсэн байх магадлалтай тул өрхүүдийн бизнес эрхлэх байдал бага байх боломжтой.

Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн сарын дундаж орлого нь 1,460.7 мянган төгрөг, зарлага нь 1,113.6 мянган төгрөг байна. (ЗУРАГ 6). Өрхүүдийн зарлагыг ерөнхий ангиллаар нь авч үзэхэд, сарын дундаж хүнсний зардал 597.0 мянган төгрөг, хүнсний бус зардал 517.4 мянган төгрөг байгаа нь өрхийн нийт хэрэглээний тал гаруй хувийг хүнсний зардал эзэлж буйг харуулж байна. Сарын дундаж орлого, зарлагыг гадаадад амьдарч байгаа гишүүдийн тооны бүлэглэлээр авч үзэхэд харьцангуй ялгаа багатай, олон гишүүн нь гадаадад оршин сууж буй өрхүүдийн хэрэглээ бусад өрхөөс бага зэрэг өндөр байна.

ЗУРАГ 6. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ХЭМЖЭЭ (ТӨГРӨГ), ГАДААД УЛСАД АМЬДАРДАГ ГИШҮҮДИЙН ТООГООР




3.2. Гадаадад шилжигчдийн шинж байдал

Энэхүү бүлэгт гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн өгсөн мэдээлэлд үндэслэн Монгол Улсаас гадаад улсад оршин сууж буй иргэдийн тоо, хүн ам зүйн шинж байдал, шилжих хөдөлгөөнд оролцсон зорилго, гадаадад байгаа хугацаа зэргийг авч үзсэн.


Судалгаагаар, гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн 106,534 хүн нь гадаад улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадад шилжигчид байна. Гадаадад шилжигчдийг оршин суугаа улсаар нь авч үзвэл, хамгийн олон иргэн шилжин суурьшсан орнууд нь Бүгд Найрамдах Солонгос Улс (30.7 хувь), Америкийн Нэгдсэн Улс (12.3 хувь), Япон Улс (9.9 хувь), Бүгд Найрамдах Чех Улс (6.9 хувь), Шведийн Вант Улс (5.7 хувь) байна. Иргэдийн оршин сууж буй улсуудыг бүсчлэн харвал, Ази тивийн орнууд руу хамгийн олон, түүнчлэн Европ тив, тэр дотроо Шенгений бүсийн орнууд руу Монгол Улсын иргэдийн шилжин суурьших байдал элбэг байна (ЗУРАГ 7).

ЗУРАГ 7. ГАДААДАД ШИЛЖИГЧ МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ХУВЬ, ОРШИН СУУГАА УЛСААР



Суваргаас гадаадад шилжигч Монгол Улсын иргэдийн дийлэнх нь ид хөдөлмөрийн буюу 20-54 насныхан байгаа бөгөөд хүйсийн хувьд 35-аас дээш насныхан дунд эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс харьцангуй илүү байгаа нь харагдаж байна (ЗУРАГ 8). Насны ерөнхий статистикуудыг харвал гадаадад шилжигчдийн дундаж нас 32.1, медиан нас 32.0 байгаа нь улсын дундаж хүн амын насны бүтцийн үзүүлэлтүүдээс арай ахимаг, ид хөдөлмөрийн насны иргэд гадаадад их байгааг баталж байна.

ЗУРАГ 8. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ТОО, НАС ХҮЙСИЙН БҮТЦЭЭР



Монгол Улсын иргэд олноор суурьшдаг улсууд дахь хүн амыг насны ерөнхий бүтцээр нь харвал (ХҮСНЭГТ 5), БНСУ, Япон зэрэг Азийн орнуудад их дээд сургуульд суралцах болон хөдөлмөр эрхлэх идэвхтэй нас болох 20-35 насны залуучууд хамгийн их, харин АНУ болон Европын орнуудад 35-аас дээш хөдөлмөрийн насныхан харьцангуй их суурьшсан онцлог ажиглагдаж байна. Гадаадад шилжигч хүн амын дунд 0-19 насны хүүхдүүд 17.3 хувь байгаагаас Европын орнуудад шилжин суурьшигчид 0-19 насны хүүхдүүдтэйгээ хамт тухайн оронд амьдрах байдал өндөр байна.

Гадаадад шилжигч Монгол Улсын иргэдийн хүйсийн бүтцийг харвал 46.1 хувь нь эрэгтэй, 53.9 хувь нь эмэгтэй байна. Ийнхүү эмэгтэйчүүдийн жин эрэгтэйчүүдийнхээс их байгаа байдал Азиас бусад тивийн орнуудад амьдарч байгаа хүн амын дунд илүүтэй ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 5. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, НАС, ХҮЙСЭЭР, ОРШИН СУУЖ БУЙ УЛСААР

Насны бүлэг	Оршин сууж буй улс						Нийт шилжигчид
	БНСУ	АНУ	Япон	БНЧУ	ШВУ	Бусад	
Насны бүлэг							
0-19	15.8	15.5	11.7	18.3	35.7	17.8	17.3
20-34	41.8	27.5	66.3	35.9	17.4	42.0	40.8
35-49	32.6	37.2	21.1	31.3	38.7	27.7	30.6
50, түүнээс дээш (үүнээс, 60+ насных)	9.8 (1.1)	19.8 (3.2)	1.0 (0.0)	14.5 (5.7)	8.2 (0.0)	12.5 (3.4)	11.3 (2.3)
Дундаж нас	32.4	35.4	28.4	33.2	32.1	31.8	32.1
Медиан нас	32.0	35.0	28.0	32.0	35.0	30.0	32.0
Хүйс							
Эрэгтэй	48.8	42.6	50.9	46.0	44.9	43.8	46.1
Эмэгтэй	51.2	57.4	49.1	54.0	55.1	56.2	53.9
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гадаад улсад оршин суугаа иргэдийн тоо	32 742	13 110	10 548	7 402	6 072	36 660	106 534

Гадаадад шилжигчдийн тухайн улсад амьдарч буй хугацааг судлахад, 9.6 хувь нь 1 жил, 40.0 хувь нь 2-5 жил, 28.6 хувь нь 6-10 жил, 21.8 хувь нь 11, түүнээс олон жил амьдарч байна. (ХҮСНЭГТ 6).

ХҮСНЭГТ 6. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ТУХАЙН УЛСДАА АМЬДАРСАН ХУГАЦААГААР, ОРШИН СУУЖ БУЙ УЛСААР

Оршин сууж буй улс	Тухайн улсад амьдарч буй хугацаа					Бүгд	Гадаад улсад оршин суугаа иргэдийн тоо
	1 жил	2-5 жил	6-10 жил	10-аас дээш жил	Дундаж (жил)		
БНСУ	11.6	46.9	28.9	12.6	5.7	100.0	32 741
АНУ	4.1	20.8	34.2	40.9	10.4	100.0	13 110
Япон	12.7	53.5	24.1	9.7	5.1	100.0	10 548
БНЧУ	8.5	38.1	26.2	27.2	8.2	100.0	7 402
ШВУ	0.0	43.0	33.9	23.1	7.4	100.0	6 072
Казахстан	16.7	45.1	19.7	18.5	6.4	100.0	4 760
Турк	11.0	53.5	30.0	5.5	4.8	100.0	3 891
ХБНГУ	4.3	26.7	25.5	43.5	12.7	100.0	4 160
Австрали	23.9	42.9	27.0	6.2	4.5	100.0	4 119
Швейцар	2.0	7.7	36.9	53.4	11.3	100.0	2 431
Франц	4.1	15.5	48.3	32.1	10.2	100.0	2 000
Австри	0.0	27.1	33.3	39.6	9.7	100.0	1 534
ИБУИНВУ	0.0	18.5	24.2	57.3	12.6	100.0	1 484
ОХУ	6.1	55.3	29.1	9.5	6.2	100.0	1 863
БНХАУ	9.3	57.0	19.4	14.3	5.9	100.0	1 223
Бусад улс	12.6	37.7	24.1	25.6	7.4	100.0	9 196
Нийт шилжигчид	9.6	40.0	28.6	21.8	7.2	100.0	106 534

Иргэдийн гадаадад амьдарсан дундаж хугацаа харьцангуй урт буюу 7.2 жил байгаа ч БНСУ, Япон зэрэг ихэнх шилжигчид очиж амьдарч буй Азийн орнуудын тухайд хоёр орны засгийн газар хооронд хийгдсэн гэрээ, хэлэлцээрүүдийн дагуу Монгол Улсын иргэд богино хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр болон үйлдвэрлэлийн дадлагажигчаар ажиллах байдал их тул тэдгээр оронд шилжсэн иргэд дунджаас богино хугацаанд оршин сууж буй үр дүн гарсан байна. Мөн Монгол Улстай хөрш зэргэлдээ, ойрхон БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Казахстан зэрэг орнуудад оршин сууж буй иргэд ч харьцангуй богино хугацаанд оршин сууж байгаагаас дүгнэвэл, газарзүйн байрлалаар ойр бүс, орнууд руу шилжих хөдөлгөөн нь олон тооны хүн амыг хамарсан хэдий ч богино хугацаатай байгаа онцлог харагдаж байна.

Харин Монгол Улсаас Европын ихэнх орнууд болон АНУ-д шилжин суурьшсан хүн амын тухайд, талаас илүү хувь нь харьцангуй удаан буюу 5-аас олон жил тухайн улсдаа амьдарч байна. Энэ нь газарзүйн байрлалаар ирж, очиход холоос гадна тэдгээр оронд иргэдийн байр сууриа олсон байдал, ажиллах, амьдрах нөхцөл болон нийгмийн үйлчилгээний таатай байдал зэрэг шилжих хөдөлгөөний татах хүчин зүйлстэй холбоотой болохыг дараагийн бүлгүүд дэх судалгааны үр дүн харуулсан.

Иргэдийн гадаад улсад шилжсэн гол зорилгыг Монгол Улс дахь өрхийн гишүүд нь хэрхэн мэдээлснийг ЗУРАГ 9-д харуулав.

ЗУРАГ 9. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ТУХАЙН УЛСАД ОЧСОН ГОЛ ЗОРИЛГООР



Зорилгуудыг өндөр жин эзлэх байдлаар нь эрэмбэлбэл хувиараа ажиллах, Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуух хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, албан томилолтоор ажиллах зэрэг эдийн засгийн холбогдолтой зорилго (44.3 хувь) бусдаас давамгайлж байна. Түүний дараа, боловсролтой холбоотой зорилго 35.9 хувьтайгаар жагсаж байна. Эдгээрээс гадна гадаадад шилжсэн иргэдийн 13.1 хувь нь гэр бүлээ дагалдах⁴, 3.6 хувь нь гадаадад суурьших болох цагаачлан үлдэх, 0.8 хувь нь б, түүнээс дээш сарын хугацаатайгаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор, үлдсэн хэсэг нь бусад зорилгоор гадаад оронд очсон байна.

Гадаадад шилжигчдийн шилжих хөдөлгөөнд оролцсон зорилгыг явсан улс орноор нь үзвэл (ХҮСНЭГТ 7) онцлог үр дүн ажиглагдаж байна. Тухайлбал, сүүлийн үед иргэдийн өндөр хөгжилтэй оронд суралцах хүсэл сонирхол, зарим оронд тэтгэлгээр суралцах боломж нэмэгдэж байгаа зэргээс үүдэн боловсролын зорилготой шилжих хөдөлгөөн ОХУ, БНХАУ, Австрали, ИБУИНВУ, ХБНГУ, Япон зэрэг улсад шилжигчдийн дунд бусад зорилготой шилжилтээс өндөр жин (41.9-72.7 хувь) эзэлж байна. Харин эдийн засгийн буюу ажил хөдөлмөр эрхэлж, амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилготой шилжих хөдөлгөөн (хувиараа ажиллах, хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, албан томилолтоор ажиллахаар шилжих хөдөлгөөн)-д оролцох байдал БНЧУ, БНСУ, Турк, Швед, Казахстан зэрэг орнууд руу шилжигчдийн дунд харьцангуй өндөр (43.5-75.8 хувь) байна.

ХҮСНЭГТ 7. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ТУХАЙН УЛСАД ОЧСОН ГОЛ ЗОРИЛГООР, ОРШИН СУУЖ БҮЙ УЛСААР


Оршин сууж буй улс	Тухайн улсад шилжин очсон гол зорилго							Бүгд	Гадаад улсад оршин суугаа иргэдийн тоо
	Суралцах	Хувиараа ажиллах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Гэр бүлээ дагалдан	Суурьших, цагаачлах	Бусад		
БНСУ	34.8	39.2	11.1	0.00	11.0	0.9	3.0	100.0	32 741
АНУ	35.8	35.4	2.2	0.0	16.8	8.7	1.1	100.0	13 110
Япон	47.2	21.9	18.8	0.0	8.1	0.7	3.3	100.0	10 548
Чех	6.6	38.8	38.0	0.3	9.2	0.8	6.3	100.0	7 402
Швед	12.0	39.0	7.6	0.0	29.6	6.0	5.8	100.0	6 072
Казахстан	40.7	40.9	2.6	0.0	9.4	5.1	1.3	100.0	4 760
ХБНГУ	48.7	30.6	5.7	0.0	6.7	6.2	2.1	100.0	4 160
Австрали	57.7	18.1	3.0	0.8	10.9	6.1	3.4	100.0	4 119
Турк	32.3	49.3	0.6	0.0	17.8	0.0	0.0	100.0	3 891
Швейцар	21.9	34.7	2.7	0.0	32.3	1.4	7.0	100.0	2 431
Франц	23.9	31.1	7.1	0.0	17.1	16.8	4.0	100.0	2 000
ОХУ	72.7	13.1	2.1	0.0	6.5	5.6	0.0	100.0	1 863
Австри	43.3	41.1	2.2	0.0	5.3	4.4	3.7	100.0	1 534
ИБУИНВУ	53.4	27.0	0.0	0.0	12.5	7.1	0.0	100.0	1 484
БНХАУ	60.9	20.9	2.0	0.0	6.1	7.4	2.7	100.0	1 223
Бусад улс	41.6	18.9	15.6	0.9	14.6	4.9	3.5	100.0	9 196
Нийт шилжигчид	35.9	33.5	10.7	0.1	13.1	3.6	3.1	100.0	106 534

⁴ Гадаадад суралцах, хөдөлмөр эрхлэх, байнга оршин суух болон бусад шалтгаанаар оршин суугаа иргэнийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд, гадаадын иргэнтэй гэр бүл болсон иргэн, түүний 16 хүртэлх насны Монгол Улсын харьяат хүүхэд багтана.

Хөгжиж буй орнуудын хүн амыг гадаад улсад шилжих хөдөлгөөнд оролцоход нөлөөлдөг томоохон түлхэх хүчин зүйлсийн нэг нь шилжих хөдөлгөөний илгээгч улсууд дахь хөдөлмөрийн зах зээлийн харьцангуй сул талууд байдаг. Хөдөлмөрийн зах зээл дээр ажил горилогчдод тохирох ажлын байр олдохгүй байх, цалин хөлс харьцангуй доогуур байх, хөдөлмөрийн орчин нөхцөл тааруу байх зэрэг хөдөлмөрийн зах зээлийн сул талуудаас үүдэн зарим шилжигчид илүү таатай орчин, нөхцөлтэй улс орнуудыг зорих нь олон улс оронд ажиглагддаг. Энэхүү таамаглалын хүрээнд бид Монгол Улсаас гадаад улсад шилжсэн иргэдийн шилжихээс өмнөх хөдөлмөр эрхлэлтийн байдлын зарим асуултыг судалгаандаа оруулан судалсан.


Монгол Улсаас гадаадад шилжигч нийт иргэдийн 87.9 хувь (93659 хүн) нь судалгааны үед 16, түүнээс дээш настай буюу олон улсын ангиллаар хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн иргэд байсан. Тус иргэдийн 43.7 хувь нь гадаад улсыг зорихын өмнө ямар нэгэн ажил, хөдөлмөр эрхэлж байсан ба бусад нь суралцаж байсан, шилжихээс өмнө хөдөлмөрийн насанд хүрээгүй байсан, ажилгүй байсан зэрэг шалтгаанаар ажил хийж байгаагүй байна (ЗУРАГ 10). Энэ байдал нь шилжигчдийн хүйсээр онцлох ялгаагүй байв.

ЗУРАГ 10. 16, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, ШИЛЖИЛТЭЭС ӨМНӨХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР, ХҮЙСЭЭР



Гадаад улсыг зорихоосоо өмнө хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн эрхэлж байсан хөдөлмөрийн хэлбэрийг судлахад (ЗУРАГ 11), 81.8 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 12.6 хувь нь бие даасан ажиллагч, 3.1 хувь нь өрхийн үйлдвэрлэлд хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн, 1.2 хувь нь ажил олгогч, 1.3 хувь нь бусад төрлийн хөдөлмөр эрхлэгч байжээ. Шилжилтээс өмнө эрэгтэйчүүдийн цалин хөлстэй хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс арай өндөр, харин эмэгтэйчүүдийн хувьд хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүний хөдөлмөр эрхлэх байдал эрэгтэйчүүдийнхээс арай өндөр байжээ.

ЗУРАГ 11. ГАДААД УЛСАД ЯВАХААС ӨМНӨ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙСАН ГАДААДАД ШИЛЖИГЧИД (15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ)-ИЙН ХУВЬ, ЭРХЭЛЖ БАЙСАН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛБЭРЭЭР, ХҮЙСЭЭР



3.3. Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрх болон гадаадад шилжигчид хоорондын хувийн шилжүүлэг

Олон улсын хил дамнасан шилжих хөдөлгөөнөөс илгээгч болон хүлээн авагч улс орнуудын аль аль нь “хожих” боломжтой байдаг. Тухайлбал, шилжигчдийг хүлээн авагч улс орнууд өөрсдийн хөдөлмөрийн зах зээлд дутагдалтай байгаа хөдөлмөрийн нийлүүлэлтээ гадаад шилжин ирэгчдээр нөхөж чаддаг бол шилжигчдээ илгээсэн улс орнуудад гадаадаас тодорхой хэмжээний мөнгөн гуйвуулгын урсгал шилжигчдээс орж ирж, микро болон макро түвшний эдийн засагт эерэг үр нөлөө үзүүлдэг. Тэгвэл, Монгол Улсын хүн амын гадаадад шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэйгээр шилжих хөдөлгөөний илгээгч өрх болон гадаадад шилжигч хооронд хийгдэж буй хувийн шилжүүлгийн нэр төрөл, хэмжээ, давтамж, түүний зарцуулалт, өрхийн амьжиргаанд нөлөөлөх байдал зэргийг тойрсон асуудлыг судалсан үр дүнг энэхүү бүлэгт танилцуулж байна.

Монгол Улсад байгаа шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн гадаад улсад амьдарч буй 18, түүнээс дээш насны шилжигчдээсээ сүүлийн 12 сарын хугацаанд хүлээн авсан хувийн шилжүүлэг буюу мөнгөн гуйвуулга, мөнгөн бус илгээмжтэй холбоотой асуудлыг тайлангийн 3.3.1 хэсэгт, харин илгээгч өрхөөс гадаадад шилжигч гишүүддээ илгээсэн мөнгөн гуйвуулга, мөнгөн бус илгээмжийн асуудлыг 3.3.2 хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

3.3.1. Өрхийн гадаадад шилжигч гишүүнээс хүлээн авсан гуйвуулга, илгээмж

Өрхийн судалгаагаар Монгол Улсад оршин суугаа гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд гадаадад шилжигч гишүүдээсээ мөнгөн гуйвуулга, мөнгөн бус эд зүйлсийн илгээмж хүлээн авсан байдлыг судлахдаа 18, түүнээс дээш насны шилжигч тус бүрээс өрхөд гуйвуулга, илгээмж хүлээн авсан байдлыг нь дэлгэрүүлж асуусан⁵. Энэ нь хувийн шилжүүлэгтэй холбоотой мэдээллийн боловсруулалт, шинжилгээг өрхийн хувьд болон гадаадад шилжигч хувь хүмүүсийн хувьд зэрэг тооцоолон гаргах боломжтой болгосон юм. Агуулгын хувьд, шилжүүлэг илгээгч болон хүлээн авагч хооронд хийгдсэн шилжүүлгийн нэр төрөл, мөнгөн дүн, давтамж, гуйвуулга илгээдэг суваг буюу үйлчилгээ, шилжүүлэг илгээхтэй холбоотой хүндрэл бэрхшээл, шилжүүлгийн хэрэглээ, үр нөлөө зэргийг дэлгэрүүлэн асууж судалсан.

Монгол Улс дахь гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 95.2 хувь, гадаадад шилжигч Монгол Улсын иргэдийн 95.1 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд мэдээлэл солилцох, мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмж хүлээн авах, илгээх, гадаад улс руу хэн нэгнээ явуулах зэрэг зорилгоор хоорондоо тогтмол холбогдсон байна.

Гадаадад шилжигчдээс илгээгч өрхүүд шилжүүлэг хүлээн авсан байдлыг өрхийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдлаар задлан ХҮСНЭГТ 8-д харуулав. Судалгаагаар, сүүлийн 12 сарын хугацаанд нийт 22622 өрх буюу гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 39.1 хувь нь гадаадад шилжигч гишүүдээсээ мөнгөн гуйвуулга ба мөнгөн бус эд зүйлс, эсхүл тэдгээрийн аль нэгийг хүлээн авсан байна. Хүлээн авсан шилжүүлгийг нэр төрлөөр нь харвал, давхардсан тоогоор 20652 өрх мөнгөн гуйвуулга, 9854 өрх мөнгөн бус илгээмж хүлээн авчээ.

Шилжүүлэг хүлээн авсан байдал өрхийн амьдарч буй хот, хөдөө гэсэн байршлаар бараг ялгаагүй байгаа ч ам бүлийн тоо, шилжигчдийн эзгүйд өрхөд байгаа хөдөлмөр эрхэлдэг хүний тоо, өрхийн орлогын байдал, өрхөөс гадаадад оршин сууж буй хүний тоо зэрэг үзүүлэлтүүдээр нэлээд ялгаатай байна. Тухайлбал, гадаадад шилжигчдийг оролцуулаагүй тооцсон өрхийн ам бүлийн тоо цөөн, шилжигчдийн эзгүйд өрхөд нь хөдөлмөр эрхэлдэг хүн үлдээгүй юм уу цөөн үлдсэн, түүнчлэн өрхийн орлогын хэмжээ бага байх тусам гадаад дахь шилжигчдээс

⁵ Гадаад улсад байгаа иргэдээс Монгол Улс дахь өрхийн гишүүддээ илгээсэн хувийн шилжүүлгийн асуултыг гадаадад байгаа 18, түүнээс дээш насны иргэн бүрээс асуусан. Хэрэв шилжих хөдөлгөөний илгээгч өрхөөс гадаадад явсан гишүүд дунд 18, түүнээс дээш насны иргэн байхгүй бол тухайн өрхийг хувийн шилжүүлэг хүлээн аваагүй өрх гэж тооцсон.

шилжүүлэг хүлээн авах байдал их байна. Энэ нь шилжих хөдөлгөөнд оролцогчдын уугуул өрхөд гуйвуулга илгээх сэдлийг тайлбарладаг гуйвуулгын талаарх онолуудын тайлбарыг баталгаажуулсан үр дүн байв. Өөрөөр хэлбэл, гадаадад шилжих хөдөлгөөнд оролцогчид ихэнх нь хөдөлмөрийн насны, эдийн засгийн зорилготойгоор шилжсэн иргэд байсан тул ар гэртээ үлдсэн хүүхэд, настан зэрэг хүн амд мөнгөн гуйвуулга, эд зүйлсийн илгээмж илгээж, амьжиргаа, хэрэглээг нь хангахад анхаардаг байна. Ялангуяа өрхөөс гадаадад шилжсэн хүний тоо 1 юм уу 2 байхад эх орон дахь өрхөд шилжүүлэг илгээх байдал өндөр байгаа нь эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх зэрэг ойр дотны гэр бүлийн гишүүдээ гэртээ үлдээн шилжсэн тохиолдлуудтай холбоотой байв. Харин гадаад руу 3, түүнээс олуулаа шилжин явсан иргэдээс эх орон дахь өрх рүүгээ шилжүүлэг илгээх байдал харьцангуй бага байгаа нь үндсэн гэр бүлийн гишүүд гадаад руу хамт явсантай холбоотой байх магадлалтай.

ХҮСНЭГТ 8. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХИЙН ХУВЬ, СҮҮЛИЙН 12 САРД ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДЭЭСЭЭ ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН ЭСЭХЭЭР, ӨРХИЙН ШИНЖ БАЙДЛААР

Өрхийн шинж байдлын үзүүлэлтүүд	Сүүлийн 12 сард гадаадад буй гишүүдээс хувийн шилжүүлэг хүлээн авсан эсэх		Бүгд	Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрх
	тийм	үгүй		
Өрхийн байршил				
Хот	38.9	61.1	100.0	52 362
Хөдөө	41.0	59.0	100.0	5 534
Өрхийн ам бүлийн тоо				
1-2 гишүүнтэй	41.0	59.0	100.0	24 532
3-4 гишүүнтэй	39.8	60.2	100.0	19 497
5, түүнээс олон гишүүнтэй	34.6	65.4	100.0	13 867
Өрх дэх хөдөлмөр эрхэлдэг хүний тоо				
байхгүй	42.8	57.2	100.0	23 755
1 хүн	39.8	60.2	100.0	20 649
2 хүн	32.6	67.4	100.0	11 124
3, түүнээс олон хүн	26.0	74.0	100.0	2 368
Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)				
800,000 хүртэл	40.6	59.4	100.0	15 643
800,001-1,190,000	43.0	57.0	100.0	13 340
1,190,001-2,000,000	39.0	61.0	100.0	20 076
2,000,001, түүнээс дээш	30.7	69.3	100.0	8 837
Өрхөөс гадаад улсад оршин сууж буй гишүүний тоо				
1 хүн	37.2	62.8	100.0	41 933
2 хүн	49.6	50.4	100.0	10 211
3, түүнээс олон хүн	34.1	65.9	100.0	5 752
Нийт өрх	39.1	60.9	100.0	57 896

Дээрх үр дүнг хувийн шилжүүлэг илгээсэн иргэдтэй холбон судалсан үр дүнг ХҮСНЭГТ 9-д харуулав. Асуултыг гадаадад шилжсэн 18, түүнээс дээш насны 92795 иргэн тус бүрийн хувьд асуусан ба тэдний 41.8 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс дахь өрхдөө хувийн шилжүүлэг илгээсэн гэж өрхүүд мэдээллээ. Хувийн шилжүүлэг илгээсэн тохиолдлууд дунд 12.5 хувь нь мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмжийн аль алиныг, 25.4 хувь нь зөвхөн мөнгөн гуйвуулга, 3.9 хувь нь зөвхөн мөнгөн бус илгээмж илгээсэн тохиолдол байв.

ХҮСНЭГТ 9. ИЛГЭЭГЧ ӨРХӨӨС ГАДААДАД ШИЛЖИГЧ 18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН ХУВЬ, МОНГОЛ УЛС ДАХЬ ӨРХДӨӨ ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН БАЙДЛААР, ШИЛЖИГЧИЙН ШИНЖ БАЙДЛААР


Шилжигчдийн шинж байдлын үзүүлэлтүүд	Сүүлийн 12 сард Монгол Улс дахь өрхдөө хувийн шилжүүлэг илгээсэн байдал				Бүгд	Гадаад улсад оршин суугаа 18-аас дээш насны иргэдийн тоо
	Гуйвуулга, илгээмж аль алийг илгээсэн	Зөвхөн мөнгөн гуйвуулга илгээсэн	Зөвхөн мөнгөн бус илгээмж илгээсэн	Гуйвуулга, илгээмж илгээгээгүй		
Шилжигчдийн нас						
18-34	8.5	22.3	4.0	65.2	100.0	48 152
35-49	17.4	31.0	3.9	47.6	100.0	32 583
50, түүнээс дээш	15.0	22.5	3.3	59.1	100.0	12 059
Шилжигчдийн хүйс						
Эрэгтэй	10.2	26.2	3.2	60.3	100.0	42 427
Эмэгтэй	14.4	24.7	4.4	56.5	100.0	50 368
Шилжигчдийн оршин суугаа улс						
БНСУ	16.9	28.8	3.8	50.5	100.0	29 688
АНУ	17.4	19.1	5.4	58.1	100.0	11357
Япон	11.1	30.4	3.8	54.7	100.0	9 689
БНЧУ	7.3	24.5	4.5	63.7	100.0	6 238
Казахстан	0.0	9.9	0.7	89.4	100.0	4 760
ШВУ	6.4	27.4	5.1	61.0	100.0	3 991
Австрали	7.7	30.0	1.6	60.6	100.0	3 602
ХБНГУ	14.9	28.9	7.1	49.1	100.0	3 544
Турк	12.5	17.5	4.7	65.3	100.0	3 096
Франц	3.7	37.2	1.9	57.1	100.0	1 721
Швейцар	16.5	30.5	2.5	50.5	100.0	1 637
Австри	26.1	21.0	4.8	48.0	100.0	1 534
ИБУИНВУ	7.2	19.2	4.0	69.6	100.0	1 029
ОХУ	2.1	1.8	1.3	94.8	100.0	1 863
БНХАУ	4.7	30.2	4.8	60.4	100.0	1 222
Бусад	8.8	26.7	3.1	61.4	100.0	7 823
Шилжигчдийн гадаад улсад амьдарсан хугацаа						
6 сараас 1 жил	2.7	17.3	2.8	77.2	100.0	8 627
1.1-5 жил	12.3	27.0	4.0	56.6	100.0	36 487
5.1-10 жил	14.4	24.3	4.3	57.0	100.0	26 548
10-аас дээш жил	14.3	27.3	3.5	54.9	100.0	21 133
18, түүнээс дээш насны нийт шилжигчид	12.5	25.4	3.9	58.2	100.0	92 795

Шилжүүлэг илгээсэн байдал шилжигчдийн хүн ам зүйн шинж байдлаар хэр ялгаатай байгааг харахад, 35 хүртэлх насны шилжигчдийг бодвол 35-аас дээш насны, тэр дундаа 35-49 насны шилжигчдийн эх орон дахь өрхдөө шилжүүлэг илгээсэн байдал (52.4 хувь) 1.5 дахин өндөр байна. Мөн гадаадад шилжсэн эмэгтэйчүүдийн 43.5 хувь шилжүүлэг илгээсэн байгаа нь эрэгтэйчүүдийнхээс бага зэрэг илүү байна.

Оршин суугаа улсаар нь харвал БНСУ, ХБНГУ, Япон, АНУ, Австри, Швейцар, Франц зэрэг орнууд дахь шилжигчдээс шилжүүлэг илгээсэн байдал (шилжигчдийн 41.9-52.0 хувь) бусад оронд байгаа шилжигчдийнхээс илүү байв. Гадаад улсад амьдарсан хугацааны хувьд тухайн улсдаа удаан амьдарсан байх тусам шилжигчдээс эх орон дахь өрхдөө гуйвуулга, илгээмж илгээх байдал нь илүү байгаа талаар өрхүүд мэдээлсэн байна.


Гадаадаас Монгол Улс дахь өрхдөө мөнгөн гуйвуулга илгээсэн 35135 иргэний мөнгө гуйвуулсан давтамжийг судлахад, сүүлийн нэг жилийн дотор 47.0 хувь нь 1-ээс 3 удаа, 30.8 хувь нь 4-өөс 6 удаа, 22.2 хувь нь 7-оос дээш удаагийн давтамжтайгаар илгээсэн талаар мөнгө хүлээн авагч өрхүүд мэдээллээ (ЗУРАГ 12). Мөнгө гуйвуулдаг давтамжийн тоо хүйсээр бага зэрэг ялгаатай буюу эмэгтэй шилжигчид эрэгтэй шилжигчдийг бодвол арай олон давтамжтайгаар өрхдөө мөнгө илгээдэг нь харагдсан. Тухайлбал, сүүлийн 12 сарын хугацаанд мөнгө гуйвуулсан иргэд дунджаар 4.9 удаа гуйвуулга илгээсэн байсан ба эмэгтэй шилжигчдийн гуйвуулга илгээсэн дундаж тоо (5.1) нь эрэгтэйчүүдийнх (4.7)-ээс арай олон байв.

ЗУРАГ 12. СҮҮЛИЙН 12 САРД МОНГОЛ УЛСАД СУУГАА ӨРХДӨӨ МӨНГӨН ГУЙВУУЛГА ИЛГЭЭСЭН ГАДААД УЛСАД ОРШИН СУУЖ БУЙ 18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН ХУВЬ, ГУЙВУУЛГА ИЛГЭЭСЭН ДАВТАМЖААР, ХҮЙСЭЭР



Гадаадаас Монгол Улс дахь өрхүүд рүү илгээгдсэн мөнгөн гуйвуулгын ихэнх тохиолдол (94.0 хувь) нь албан бүртгэлтэй шугамууд болох банк, банк бус санхүүгийн байгууллагаар, бусад нь албан бус шугам буюу макро эдийн засагт бүртгэгддэггүй хэлбэрээр, тухайлбал хувь хүнээр, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй байгууллага болох каргоны газруудаар дамжин хийгдсэн байна (ЗУРАГ 13).

ЗУРАГ 13. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН ГУЙВУУЛГА ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ГУЙВУУЛГА ХҮЛЭЭН АВАХДАА АШИГЛАСАН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР



Сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улсад оршин суугаа өрхийн гишүүддээ гадаадаас мөнгөн бус илгээмж илгээсэн 15166 шилжигчийн илгээсэн эд зүйлсийн талаарх мэдээллийг ЗУРАГ 14-т харуулав. Давхардсан тоогоор, илгээмж илгээсэн иргэдийн дунд өдөр тутмын хэрэглээний үнэ өртөг харьцангуй багатай зүйлс, тухайлбал гутал, хувцас (73.6 хувь), хүнсний бүтээгдэхүүн (38.4 хувь), эм, витамин, гоо сайхны төрлийн бүтээгдэхүүн (36.7 хувь) зэргийг илгээсэн байдал өндөр байна. Үүнээс гадна харьцангуй өндөр үнэтэй удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүн болох гэр ахуйн цахилгаан хэрэгсэл (14.4 хувь), гар утас, таблет, компьютер (10.5 хувь), машин (1.3 хувь) зэргийг илгээсэн шилжигчдийн хувь нийт дүнгээрээ 26.2 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 14. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР*



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Өрхүүд гадаад улсад оршин суугаа шилжигчдээсээ мөнгөн бус илгээмж хүлээн авсан байдлыг шилжигчдийн оршин суугаа улсаар харуулсан үр дүнг ХҮСНЭГТ 10-т харуулав. Бусад оронд байгаа мөнгөн бус илгээмж илгээдэг шилжигчидтэй харьцуулахад БНСУ, Япон зэрэг Азийн орнууд, ХБНГУ, Австрали, ШВУ, БНЧУ, Швейцар зэрэг Шенгений бүсийн орнууд, мөн АНУ, Турк зэрэг орноос илгээмж илгээгчид өдөр тутмын болон удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүний аль алийг буюу илүү олон нэр төрлийн эд зүйлсийг Монгол Улс дахь өрхдөө илгээдэг болох нь харагдаж байна.


ХҮСНЭГТ 10. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ*, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР, ШИЛЖИГЧИЙН ОРШИН СУУГАА УЛСААР

Шилжигчийн оршин суугаа улс	Өрхийн хүлээн авсан бүтээгдэхүүний төрөл							Илгээмж илгээсэн 18+ насны шилжигчдийн тоо
	Хүнс	Гутал, хувцас	Эм, витамин, гоо сайхны бүтээгдэхүүн	Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл	Гар утас, таблет, компьютер	Машин	Бусад	
БНСУ	31.5	74.5	37.2	21.8	13.8	1.9	4.5	6 145
АНУ	56.8	65.3	39.5	6.1	9.6	0	6	2 590
Япон	39.3	83.3	30.9	7.4	7	5.1	3.3	1 441
ХБНГУ	17.8	74.9	53.3	14.7	17.6	0	4.3	782
БНЧУ	23.4	68.9	41	9.1	4.6	0	0	737
Турк	23.4	89.1	29.3	6.3	6.3	0	0	534
Австри	35.7	82.8	8.6	17.2	0	0	0	475
ШВУ	50.3	76.9	37.3	7.3	7.3	0	0	461
Австрали	44.2	80	39.6	10	17.1	0	7.1	336
Швейцар	47	76.2	21.4	7.7	0	0	36.9	311
БНХАУ	0	71.1	0	0	0	0	28.9	116
ИБУИНВУ	100	100	0	0	0	0	0	115
Франц	65.5	34.5	100	0	0	0	0	97
ОХУ	100	62.3	0	0	62.3	0	0	64
Казахстан	0	0	100	100	0	0	0	33
Бусад улс	51.2	63.9	43.1	17	6.3	0	0	931
Нийт шилжигчид	38.4	73.6	36.7	14.4	10.5	1.3	4.5	15 166

*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Гадаад улсад амьдарч байгаа гишүүдээсээ сүүлийн 12 сард мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмж, эсхүл тэдгээрийн аль нэгийг хүлээн авсан 38731 тохиолдлын хувьд шилжүүлэг авахад нь хүндрэл, бэрхшээл тулгарсан байдлыг асуухад 9.3 хувьд л тодорхой төрлийн бэрхшээл тулгарсан байна. Гадаад улсад байгаа гишүүдийн илгээсэн гуйвуулга, илгээмжийг хүлээн авахад тохиолддог гол бэрхшээлүүд нь өрхийн хувьд шимтгэл өндөр (49.3 хувь), хугацаа урт буюу удаж ирдэг (29.5 хувь), алдагдах эрсдэлтэй, найдваргүй (5.4 хувь) зэрэг байна (ЗУРАГ 15).

ЗУРАГ 15. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВАХАД БЭРХШЭЭЛ ТУЛГАРСАН БАЙДЛААР



Сүүлийн 12 сарын хугацаанд гадаад улсад оршин суугаа 18, түүнээс дээш насны өрхийн гишүүдээсээ Монгол Улс дахь өрх, хүн амын хүлээн авсан мөнгөн, мөнгөн бус шилжүүлгийн хэмжээний зарим статистикийг шилжүүлэг хүлээн авагч өрхийн өгсөн мэдээлэлд суурилсан байдлаар тооцож ХҮСНЭГТ 11-д харуулав.

ХҮСНЭГТ 11. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ХҮН АМ, ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРИМ СТАТИСТИК, ШИЛЖҮҮЛГИЙН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, шилжүүлэг хүлээн авагч өрхийн мэдээлэлд суурилсан тооцоогоор.

Гадаад улсад шилжигчдээс шилжүүлэг хүлээн авсан Монгол Улсын өрх, хүн ам, шилжүүлгийн үзүүлэлтүүд	Шилжүүлгийн төрөл		
	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт
Гадаад улсад оршин суугаа 18, түүнээс дээш насны иргэдээс Монгол Улсын өрх, хүн амын хүлээн авсан шилжүүлгийн нийт дүн (сая төгрөг)	124 223.2	24 801.7	149 024.9
Тухайн шилжүүлэг хүлээн авсан нэгж өрхөд ногдох жилд хүлээн авсан шилжүүлгийн дундаж дүн (сая төгрөг)	6.0	2.5	6.6
Тухайн шилжүүлэг хүлээн авсан өрхийн тоо*	20 652	9 854	22 622
Тухайн шилжүүлэг хүлээн авсан өрхийн нэг хүнд ногдох жилд хүлээн авсан шилжүүлгийн дундаж дүн (сая төгрөг)	1.9	0.8	2.1
Тухайн шилжүүлэг хүлээн авсан өрхүүд дэх хүн амын тоо*	64 798	30 467	70 937

Тайлбар: * мөнгөн ба мөнгөн бус шилжүүлэг аль алиныг хүлээн авсан бол тоо давхардан тоологдоно.

Судалгааны мэдээлэл цуглуулалтаас өмнөх 12 сарын хугацаанд Монгол Улс дахь шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд болон хүн амд 124.2 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулга, 24.8 тэрбум төгрөгтэй дүйцэх эд зүйлсийн илгээмж, нийт дүнгээрээ 149.0 тэрбум төгрөгийн шилжүүлэг гадаадад шилжсэн иргэдээс орж ирсэн гэсэн тооцоо гарлаа. Нэгж өрхөд ногдох дүнг тооцож харвал, шилжүүлэг хүлээн авсан нэг өрхөд жилд дунджаар 6,587,658 төгрөг, тэдгээр өрхүүдэд амьдарч буй 1 хүнд жилд дунджаар 2,100,792 төгрөгийн орлого, эд зүйлс гадаад улсад оршин суугаа шилжигчдээс өрхийн эдийн засгийг дэмжин орж ирсэн байна.

Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн түүвэр судалгааны мэдээлэлд үндэслэн тооцсон дээрх дүн нь Монгол Улсын өрхүүдэд орж ирсэн гадаад хувийн шилжүүлгийн дүнгээс бага байх магадлалтай (Мөнхжаргал.Б, 2022, хх.13-14). Тодруулбал, Монгол Улсад өмнө хийгдсэн ХАОСТ, гадаадад оршин сууж буй монгол иргэдийн түүвэр судалгаанууд (ХХССТ, ХНХЯ, НҮБХАС, 2017; Солонго, 2011; МХАХН, НҮБХАС, 2005)-аас тооцвол, түүвэр судалгаагаар гуйвуулга авсан өрхүүдийн ойролцоогоор 1/3 орчим нь гуйвуулгын мэдээллээ бүрэн өгөөгүй байх магадлалтай байдаг байна. Түүнчлэн практикт эрхий хурууны дүрмээр, 0.90 корреляцитайгаар, өрхөд суурилсан түүвэр судалгаагаар гардаг хувийн гуйвуулгын дүн аливаа улсын Төлбөрийн тэнцлийн тайлангаар гардаг гуйвуулгын дүнгээс дор хаяж 1.5 дахин бага байдаг байна (Pablo, Cesar, Fajnzylber & Lopez, 2006). Монголбанкнаас гаргасан төлбөрийн тэнцлийн 2022 оны мэдээллээр Монгол Улсын гадаадаас хүлээн авсан хувийн шилжүүлэг (эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондын урсгал)-ийн хэмжээ 119.5 сая ам.доллар байгаа нь судалгаагаар гарсан үр дүнгээс (124.2 тэрбум төгрөг) 3 дахин өндөр байна. Энэ нь дээрх эрхий хурууны дүрэмтэй нийцтэй байна.

Иймд, энэхүү судалгаагаар гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдэд орж ирсэн хувийн шилжүүлгийн нийт дүнгийн тооцоог өөр аргаар зэрэгцүүлэн хийж үзсэн ба үр дүнг ХҮСНЭГТ 12-т харуулав. Нэмэлт байдлаар хийсэн тооцоонд энэхүү судалгаатай нэгэн зэрэг мэдээлэл цуглуулж, хийгдсэн ҮСХ-ны “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал” судалгааны үр дүнг нэмэлтээр ашигласан. Тус судалгаагаар гадаадад шилжин суурьшсан 18, түүнээс дээш насны 1865 иргэн хамрагдсаны 73.9 хувь нь сүүлийн 12 сард Монгол Улсад суугаа өрхдөө ямар нэгэн шилжүүлэг илгээсэн; тэдний илгээсэн мөнгөн болон мөнгөн бус эд зүйлсийн шилжүүлгийн дундаж хэмжээ 18,654,652 төгрөг байв. Энэхүү шилжүүлэг илгээгч иргэдийн өгсөн мэдээлэлд үндэслэн тооцвол, сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс дахь шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд болон хүн амд нийт 722.5 тэрбум төгрөгийн шилжүүлэг гадаадад шилжсэн иргэдээс орж ирсэн гэсэн тооцоо гарлаа.

ХҮСНЭГТ 12. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭГЧИД, ТЭДНЭЭС МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ХҮН АМЫН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН ХЭМЖЭЭ, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, шилжүүлэг илгээгч иргэдийн мэдээлэлд суурилсан тооцоогоор.

Гадаад улсаас хувийн шилжүүлэг илгээсэн хүн ам, шилжүүлгийн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ	Мэдээллийн эх үүсвэр
Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдэд тоологдсон, сүүлийн 12 сард гадаадаас шилжүүлэг илгээгч 18, түүнээс дээш насны иргэдийн тоо	(а) 38 731 иргэн	ҮСХ (2023). "Монгол улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө" түүвэр судалгаа. (гадаад улсад оршин суугаа гишүүнтэй Монгол Улсын өрхүүдээс магадлалт түүврийн аргаар сонгон судалсан тул судалгааны үр дүнг эх олонлогт тархаан дүгнэлт хийх боломжтой байсан; мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 5, 6 дугаар сард гүйцэтгэсэн)
Гадаад улсад оршин суугаа, сүүлийн 12 сард Монгол Улс дахь өрхдөө шилжүүлэг илгээсэн 18, түүнээс дээш насны иргэний илгээсэн шилжүүлгийн дундаж дүн /сүүлийн 12 сард/	(б) 18.7 сая төгрөг ⁶	ҮСХ (2023). "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал" судалгаа (гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат 18, түүнээс дээш насны иргэдээс магадлалт бус түүврийн аргаар сонгон судалсан тул судалгааны үр дүнг эх олонлогт тархаан дүгнэлт хийх боломжгүй байсан; мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 5, 6 дугаар сард гүйцэтгэсэн.)
Гадаад улсад оршин суугаа иргэдээс Монгол Улсын өрх, хүн амын хүлээн авсан шилжүүлгийн нийт дүн	(в)=(а)*(б) 722 513.3 сая төгрөг	Судлаачийн тооцоолол.

Гадаадад шилжигчдээс сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс дахь өрхүүдийн хүлээн авсан шилжүүлгийн нийт хэмжээг шилжигчдийн одоогийн амьдарч байгаа улсаар тооцсон үр дүнг ХҮСНЭГТ 13-т харуулав. Шилжүүлэг хүлээн авагч өрхийн мэдээлэлд суурилсан тооцоогоор, БНСУ, АНУ, Япон, Австрали, БНЧУ, Швейцар, ХБНГУ, Австри зэрэг орнуудад оршин суугаа шилжигчдээс ирүүлсэн шилжүүлэг нийт дүнгээрээ Монгол Улсын өрхүүдэд ирсэн шилжүүлгийн дийлэнхийг бүрдүүлсэн байна. Гэхдээ шилжүүлэг илгээгч нэг иргэний илгээсэн шилжүүлгийн дундаж дүнгээр улс орнуудыг эрэмбэлхэд БНСУ (8.1 сая), Швейцар (7.6 сая), ИБУИНВУ (7.2 сая), Австрали (7.1 сая), ХБНГУ (5.8 сая), Япон (5.3 сая) зэрэг улсад байгаа шилжүүлэг илгээгчид тус бүртээ хамгийн өндөр дундаж дүнтэй шилжүүлгийг

⁶ ҮСХ (2023). Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал судалгаагаар гадаадад байгаа иргэдийн Монгол Улс дахь өрхүүд рүү илгээсэн шилжүүлгийн дундаж дүнг тооцохдоо, тооцооллын стандарт хэлбэлзлийг багасгах үүднээс хамгийн бага дүнтэй шилжүүлэг хийсэн 1 хувь, хамгийн өндөр дүнтэй шилжүүлэг хийсэн 1 хувьтай тэнцэх хариулагчид (29 тохиолдол)-ын мэдээллийг дунджийн тооцоонд оруулаагүй.


Монгол Улс дахь өрхдөө илгээж байжээ (ХАВСРАЛТ 1). БНСУ-д оршин суугаа шилжигчдийн тоо өндөр, мөн шилжүүлэг илгээгч нэг иргэний илгээдэг шилжүүлгийн дундаж хэмжээ ч өндөр байсан тул БНСУ дахь шилжигчдээс Монгол Улсын өрхүүд рүү хамгийн их дүнтэй шилжүүлгийн урсгал орж иржээ. Харин АНУ, Япон, БНЧУ зэрэг орнуудын тухайд нэг шилжүүлэгчийн илгээдэг дүн өндөр биш ч харьцангуй олон тооны шилжигчид шилжүүлэг илгээж байгаа нь, Австрали, Швейцар, ХБНГУ, Австри зэрэг орнуудын тухайд шилжүүлэг илгээгчийн тоо олон биш ч нэг шилжүүлэгчийн илгээдэг дундаж дүн өндөр байгаа нь тус тус Монгол Улс руу илгээсэн шилжүүлгийн нийт дүн өндөр гарахад нөлөөлсөн байлаа.

ХҮСНЭГТ 13. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) МОНГОЛ УЛСЫН ӨРХҮҮДИЙН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН НИЙТ ХЭМЖЭЭ, САЯ ТӨГРӨГӨӨР, ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, ШИЛЖИГЧДИЙН ОРШИН СУУГАА УЛСААР

Шилжигчдийн оршин суугаа улс	Өрхүүдийн хүлээн авсан шилжүүлгийн нийт дүн (сая төгрөг), төрлөөр		
	Мөнгөн гуйвуулга ба илгээмж	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж
БНСУ	71 645.9	57 744.0	13 901.9
АНУ	20 818.5	16 020.4	4 798.2
Япон	13 832.0	11 734.9	2 097.1
Австрали	7 326.9	6 581.7	745.2
БНЧУ	4 934.7	4 601.7	333.0
Швейцар	4 930.0	4 323.2	606.8
ХБНГУ	4 350.8	4 052.2	298.6
Австри	3 448.0	2 374.0	1 074.1
ИБУИИНВУ	1 456.6	1 391.0	65.6
Турк	1 304.9	1 135.7	169.2
ШВУ	1 281.8	1 023.9	257.9
Казахстан	892.1	847.9	44.2
Франц	823.5	794.0	29.5
БНХАУ	736.9	712.3	24.6
ОХУ	68.3	64.9	3.3
Бусад улс	11 173.9	10 821.5	352.4
Нийт	149 024.9	124 223.2	24 801.7


Өрхүүдийн өнгөрсөн 12 сарын хугацаанд нэгж шилжигчээс хүлээн авсан гуйвуулга, илгээмжийн дүн нь илгээсэн шилжигчдийн хүн ам зүйн шинжээр ялгаатай байгаа эсэхийг судалсан үр дүнг ЗУРАГ 16-д харуулав. Өмнө өгүүлсэнчлэн эрэгтэй шилжигчдээс шилжүүлэг илгээсэн хувь эмэгтэйчүүдийнхээс бага байсан ч илгээсэн тохиолдлууд нь эмэгтэйчүүдээс дунджаар 1 сая гаруй төгрөгөөр өндөр дүнтэй шилжүүлэг илгээсэн талаар судалгааны өрхүүд мэдээлсэн байна. Түүнчлэн 35-аас дээш насны, гадаадад 1.1-5 жил амьдарч буй шилжүүлэг илгээгчдийн Монгол Улсад байгаа өрхдөө явуулсан гуйвуулга, илгээмжийн дундаж дүн бусад бүлгийнхнээс өндөр дүнтэй байсан нь харагдлаа.

ЗУРАГ 16. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ӨРХҮҮДИЙН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ТӨГРӨГ), ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭГЧИЙН ШИНЖ БАЙДЛААР



Гадаадад шилжсэн иргэдээс мөнгөн гуйвуулга хүлээн авсан өрхүүд уг орлогоо өрхийн хэрэглээнд хэрхэн хуваарилсан байдлыг ЗУРАГ 17-д харуулав.

ЗУРАГ 17. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ӨРХҮҮДИЙН ХҮЛЭЭН АВСАН ШИЛЖҮҮЛГИЙН ТОХИОЛДЛУУД, ЗАРЦУУЛАГДСАН БАЙДЛААР



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Гадаадаас өрхдөө мөнгөн гуйвуулга илгээсэн 35135 тохиолдлын 82.3 хувь нь хүлээн авагч өрхийн өдөр тутмын хэрэгцээгээ хангахад дэм болон зарцуулагдсанаас гадна давхардсан тоогоор, 47.3 хувь нь эрүүл мэнд, боловсрол зэрэг хүмүүн капиталд хөрөнгө оруулахад, 11.1 хувь нь өрхийн өр зээлийг барагдуулахад, 4.3 хувь нь байр, сууц, газар зэрэг удаан эдэлгээтэй өмч хөрөнгө худалдан авахад, 3 хувь нь хадгалахад, 2.6 хувь нь өрхийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хөрөнгө оруулалт болон ашиглагдсан байна. Өдөр тутмын хэрэгцээнээс бусад дээр дурдагдсан зарцуулалтын төрлүүд нь харьцангуй бага жин эзэлж байгаа ч өндөр дүнтэй зарлагууд байгааг анхаарч үзвэл, гадаад хувийн гуйвуулга нь хүлээн авагч өрхийн суурь хэрэгцээг хангахад төдийгүй хөрөнгө

оруулалтын шинжтэй хэрэглээг нь дэмжих, улмаар өрхүүдийн аж байдлыг сайжруулах, хүмүүн капиталгаа дэмжих зэрэгт багагүй тус нэмэр болсныг харуулж байна.

Гадаадад шилжсэн гишүүдээсээ мөнгөн, мөнгөн бус шилжүүлэг хүлээн авсан өрхүүд амьжиргаанд нь үзүүлсэн шилжүүлгийн нөлөөг өөрсдөө хэрхэн дүгнэж байгаа талаарх үр дүнг ХҮСНЭГТ 14-т харуулав. Гуйвуулга, илгээмж хүлээн авагч өрхүүд бараг бүгдээрээ буюу 95.8 хувь нь гадаадад шилжигчдийн илгээсэн шилжүүлэг өрхийн амьжиргаанд нь эерэг нөлөө үзүүлсэн, тэр дундаа 4 өрх тутмын 3 нь “их, дунд” эерэг нөлөө үзүүлсэн гэсэн байгаа нь шилжүүлгийн ач холбогдлыг өрхүүд өндрөөр үнэлж буйг харуулж байна. Өрхийн шинж байдлаар харахад хөдөөгийн, шилжигчдийг оролцуулаагүй ам бүлийн тоо 3-4 гишүүнтэй, орлого багатай өрхүүдийн шилжигчдийн илгээсэн гуйвуулга, илгээмжийн амьжиргаанд үзүүлсэн ач тус бусад бүлгээс илүүтэйгээр үнэлсэн байв.

ХҮСНЭГТ 14. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ӨРХИЙН АМЬЖИРГААНД ШИЛЖҮҮЛГИЙН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨГ ДҮГНЭСЭН БАЙДЛААР

Өрхийн шинж байдлын үзүүлэлтүүд	Өрхийн амьжиргаанд шилжүүлгийн үзүүлсэн эерэг нөлөөг дүгнэсэн байдал				Бүгд	Гадаад улсад байгаа гишүүдээсээ сүүлийн 12 сард шилжүүлэг хүлээн авсан өрхийн тоо
	Их	Дунд	Бага	Нөлөөгүй		
Өрхийн байршил						
Хот	34.4	39.1	21.9	4.6	100.0	20 354
Хөдөө	50.2	27.8	20.2	1.8	100.0	2 268
Өрхийн ам бүлийн тоо						
1-2 гишүүнтэй	36.2	37.7	20.9	5.2	100.0	10 064
3-4 гишүүнтэй	38.3	39.3	19.9	2.5	100.0	7 761
5, түүнээс олон гишүүнтэй	31.6	36.7	26.5	5.2	100.0	4 797
Өрхийн орлого (төгрөг)						
800,000 хүртэл	37.6	39.4	21.5	1.5	100.0	6 351
800,001-1,190,000	39.2	31.3	25.5	4.0	100.0	5 735
1,190,001-2,000,000	39.0	38.9	18.1	4.0	100.0	7 827
2,000,001, түүнээс дээш	16.3	46.6	25.1	12.0	100.0	2 709
Нийт өрх	36.0	38.0	21.8	4.2	100.0	22 622

Цаашид гадаадад шилжигчдээс өрхийн гишүүдийн гарт ирж буй хувийн мөнгөн гуйвуулгын хэмжээг нэмэгдүүлэх, зарцуулалтыг илүү үр дүнтэй болгохын тулд зарим арга хэмжээг хэрэгжүүлбэл шилжих хөдөлгөөний эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой юм. Үүнд, тухайлбал мөнгөн гуйвуулгын шимтгэлийг бууруулах, илүү олон улс орноос бага өртөгтэйгөөр шилжүүлэг хүлээн авах боломжтой болгох, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний боломж, хүртээмжийг улс орон даяар нэмэгдүүлэх зэрэгт чиглэсэн арга хэмжээнүүд байх боломжтой. Түүнчлэн нэн түрүүнд Засгийн газруудын гэрээтэй буюу зохион байгуулалттайгаар гадаадад хөдөлмөр эрхлэх гэрээгээр явсан иргэдийн мөнгөн гуйвуулгыг хөнгөлөлттэй зардлаар гуйвуулахад туслах, ирээдүйд нь зориулсан хадгаламж үүсгэх орчин нөхцөлийг тусгайлан бүрдүүлж өгөх зэрэг арга хэмжээ ч чухал юм. Энэ чиглэлээр,

гадаад шилжих хөдөлгөөний “илгээгч” олон оронд төрийн бодлогоор гадаад руу шилжигч иргэдээсээ хүлээн авах мөнгөн гуйвуулгын урсгалыг дэмжих дэд бүтцийг сайжруулах, мөнгөн гуйвуулгаар хуримтлал үүсгэх тал дээр нь анхаарч тодорхой нөхцөл бүрдүүлдэг туршлагауд байдаг. Тухайлбал, Филиппин Улс хөдөлмөрийн гэрээгээр гадаадад явж буй иргэдийнхээ цалингаас тодорхой хэсгийг банканд байршуулж хуримтлуулан, эх орондоо буцаж ирэхэд нь өгдөг байна.

3.3.2. Өрхөөс гадаадад шилжигчдэдээ илгээсэн гуйвуулга, илгээмж

Энэхүү бүлэгт гадаад улсад 6, түүнээс дээш сараар оршин сууж буй гишүүндээ сүүлийн 12 сард хувийн шилжүүлэг илгээсэн Монгол Улсын өрхүүдийн онцлогийг тэдний хүн ам зүйн шинж байдал, ахуйн нөхцөл, амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдээр судлан харуулав.

Судалгааны дүнгээр, сүүлийн 12 сарын хугацаанд нийт 15435 өрх буюу гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 26.7 хувь нь гадаад улсад оршин суугаа өрхийн гишүүндээ мөнгөн гуйвуулга ба мөнгөн бус эд зүйлс, эсхүл тэдгээрийн аль нэгийг илгээсэн байна (ХҮСНЭГТ 15). Өрхөөс шилжүүлсэн шилжүүлгийг нэр төрлөөр нь харвал, давхардсан тоогоор 6584 өрх нь мөнгөн гуйвуулга, 10539 өрх нь мөнгөн бус илгээмж илгээсэн байна.

Гадаадад оршин суугаа өрхийн гишүүн/гишүүддээ хувийн шилжүүлэг илгээсэн өрхүүдийг байршлаар авч үзвэл, хот, суурин газар амьдардаг өрхийн 25.8 хувь, хөдөөд амьдардаг өрхийн 34.7 хувь шилжүүлэг илгээсэн байна. Түүнчлэн гадаадад амьдардаг гишүүний тоо нь харьцангуй цөөн (1-2 хүн), өрхөд нь хөдөлмөр эрхэлдэг хүн олон байгаа, улмаар өрхийн орлого нь харьцангуй өндөр өрхүүдээс гадаадад оршин суугаа гишүүндээ шилжүүлэг илгээх байдал илүү байна.

ХҮСНЭГТ 15. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, СҮҮЛИЙН 12 САРД ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮНДЭЭ ХУВИЙН ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН ЭСЭХЭЭР, ӨРХИЙН ШИНЖ БАЙДЛААР

Өрхийн шинж байдлын үзүүлэлтүүд	Сүүлийн 12 сард гадаадад буй гишүүдэд хувийн шилжүүлэг илгээсэн эсэх		Бүгд	Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрх
	тийм	үгүй		
Өрхийн байршил				
Хот	25.8	74.2	100.0	52 362
Хөдөө	34.7	65.3	100.0	5 534
Өрхийн ам бүлийн тоо				
1-2 гишүүнтэй	23.7	76.3	100.0	24 532
3-4 гишүүнтэй	30.0	70.0	100.0	19 497
5, түүнээс олон гишүүнтэй	27.2	72.8	100.0	13 867
Өрх дэх хөдөлмөр эрхэлдэг хүний тоо				
байхгүй	20.5	79.5	100.0	23 755
1 хүн	28.0	72.0	100.0	20 649
2 хүн	33.9	66.1	100.0	11 124
3, түүнээс олон хүн	42.8	57.2	100.0	2 368
Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)				
800,000 хүртэл	18.8	81.2	100.0	15 643
800,001-1,190,000	23.9	76.1	100.0	13 340
1,190,001-2,000,000	29.8	70.2	100.0	20 076
2,000,001, түүнээс дээш	37.7	62.3	100.0	8 837
Өрхөөс гадаад улсад оршин сууж буй гишүүний тоо				
1 хүн	25.2	74.8	100.0	41 933
2 хүн	36.1	63.9	100.0	10 211
3, түүнээс олон хүн	20.4	79.6	100.0	5 752
Нийт өрх	26.7	73.3	100.0	57 896

Дээрх үр дүнг хувийн шилжүүлэг хүлээн авсан иргэдтэй холбон судалсан үр дүнг ХҮСНЭГТ 16-д харуулав. Өрхөөс илгээсэн гуйвуулга, илгээмжтэй холбоотой асуудлыг өрхөөс гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа 106534 шилжигч тус бүрийн хувьд асуусан ба тэдний 24.8 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс дахь өрхөөсөө хувийн шилжүүлэг хүлээн авсан байна. Хувийн шилжүүлэг хүлээн авсан тохиолдлууд дунд 3.1 хувь нь мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмжийн аль алиныг, 7.6 хувь нь зөвхөн мөнгөн гуйвуулга, 14.1 хувь нь зөвхөн мөнгөн бус илгээмж хүлээн авсан тохиолдол байв.

Шилжүүлэг хүлээн авсан байдал шилжигчдийн хүн ам зүйн шинж байдлаар хэр ялгаатай байгааг харахад, 18-34 насны шилжигчдийн эх орон дахь өрхөөсөө шилжүүлэг хүлээн авсан байдал (35.2 хувь) бусад шилжигчдийнхээс өндөр байна. Гадаадад шилжигчдийн шилжүүлэг хүлээн авсан байдлыг хүйсээр авч үзэхэд онцлох ялгаа харагдахгүй байна.


Оршин суугаа улсаар нь харвал ОХУ, БНСУ, Япон, Казакстан, Турк зэрэг орнуудад байгаа шилжигчид эх орон дахь өрхөөсөө шилжүүлэг хүлээн авсан байдал (шилжигчдийн 29.4-50.4 хувь) бусад оронд байгаа шилжигчдийнхээс илүү байв. Гадаад улсад амьдарсан хугацааны хувьд тухайн улсдаа удаан амьдарсан байх тусам шилжигчид эх орон дахь өрхөөсөө гуйвуулга, илгээмж хүлээн авах байдал нь бага байгааг өрхүүд мэдээлсэн байна.

ХҮСНЭГТ 16. ГАДААДАД ШИЛЖИГЧДИЙН ХУВЬ, МОНГОЛ УЛСАД СУУГАА ӨРХӨӨСӨӨ ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВСАН БАЙДЛААР, ШИЛЖИГЧДИЙН ШИНЖ БАЙДЛААР

Шилжигчдийн шинж байдлын үзүүлэлтүүд	Сүүлийн 12 сард өрхөөсөө шилжүүлэг хүлээн авсан байдал				Бүгд	Гадаад улсад оршин суугаа иргэдийн тоо
	Гуйвуулга, илгээмж алийг авсан	Зөвхөн мөнгөн гуйвуулга авсан	Зөвхөн мөнгөн бус илгээмж авсан	Гуйвуулга, илгээмж аваагүй		
Шилжигчдийн нас						
0-17	2.3	4.2	13.9	79.7	100.0	13 739
18-34	5.9	14.1	15.2	64.8	100.0	48 152
35-49	0.2	1.9	13.0	84.9	100.0	32 583
50, түүнээс дээш	0.5	1.0	12.9	85.6	100.0	12 059
Шилжигчдийн хүйс						
Эрэгтэй	2.4	9.0	13.5	75.2	100.0	49 139
Эмэгтэй	3.7	6.4	14.6	75.3	100.0	57 395
Шилжигчдийн оршин суугаа улс						
БНСУ	4.6	7.3	17.9	70.3	100.0	32 742
АНУ	1.4	1.9	13.0	83.7	100.0	13 110
Япон	4.4	9.6	20.1	66.0	100.0	10 548
БНЧУ	1.3	4.5	10.0	84.2	100.0	7 402
Казакстан	5.6	23.9	6.8	63.7	100.0	4 760
ШВУ	0.4	0.5	9.5	89.5	100.0	6 072
Австрали	0.6	8.7	10.9	79.8	100.0	4 119
ХБНГУ	0.6	3.0	14.5	81.9	100.0	4 159
Турк	5.3	13.9	10.3	70.6	100.0	3 891
Франц	0.0	1.7	11.1	87.2	100.0	2 000
Швейцарь	0.0	1.0	12.5	86.5	100.0	2 431
Австри	0.0	4.7	13.5	81.8	100.0	1 534
ИБУИНВУ	0.0	1.7	19.2	79.1	100.0	1 484
ОХУ	7.8	38.6	4.0	49.6	100.0	1 863
БНХАУ	2.0	10.1	10.6	77.2	100.0	1 222
Бусад	3.7	10.0	10.9	75.4	100.0	9 196
Шилжигчдийн гадаад улсад амьдарсан хугацаа						
1 жил	6.3	13.4	10.7	69.6	100.0	10 217
2-5 жил	5.0	11.9	16.0	67.1	100.0	42 631
6-10 жил	1.4	4.8	14.4	79.3	100.0	30 496
10-аас дээш жил	0.2	0.8	11.6	87.4	100.0	23 190
Нийт шилжигчид	3.1	7.6	14.1	75.2	100.0	106 534


Монгол Улс дахь өрхөөсөө мөнгөн гуйвуулга хүлээн авсан гадаадад оршин суугаа 36373 иргэний мөнгөн гуйвуулга хүлээн авсан давтамжийг судлахад, сүүлийн нэг жилийн дотор 63.8 хувь нь 1-ээс 3 удаа, 18.0 хувь нь 4-өөс 6 удаа, 18.2 хувь нь 7-оос дээш удаагийн давтамжтайгаар хүлээн авсан байна (ЗУРАГ 18). Мөнгөн гуйвуулга хүлээн авдаг давтамжийн тоо хүйсээр бага зэрэг ялгаатай буюу эрэгтэй шилжигчид эмэгтэй шилжигчдийг бодвол арай олон давтамжтайгаар өрхөөсөө мөнгө хүлээн авдаг нь харагдсан.

ЗУРАГ 18. СҮҮЛИЙН 12 САРД МОНГОЛ УЛСАД СУУГАА ӨРХӨӨСӨӨ МӨНГӨН ГУЙВУУЛГА ХҮЛЭЭН АВСАН ГАДААДАД ШИЛЖИГЧ ИРГЭДИЙН ХУВЬ, ГУЙВУУЛГА АВСАН ДАВТАМЖААР, ХҮЙСЭЭР




Монгол Улс дахь өрхүүдээс гадаад руу хийгдсэн хувийн мөнгөн гуйвуулгын ихэнх тохиолдол (90.7 хувь) нь албан бүртгэлтэй шугамууд болох банк, банк бус санхүүгийн байгууллагаар, бусад нь албан бус шугам буюу макро эдийн засагт бүртгэгддэггүй хэлбэрээр, тухайлбал хувь хүнээр, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй байгууллага болох каргоны газруудаар дамжин хийгдсэн байна (ЗУРАГ 19).

ЗУРАГ 19. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН ГУЙВУУЛГА ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ГУЙВУУЛГА ИЛГЭЭХДЭЭ АШИГЛАСАН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР



Сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс дахь өрхөөсөө мөнгөн бус илгээмж хүлээн авсан 18282 шилжигчдийн хүлээн авсан эд зүйлсийн талаарх мэдээллийг ЗУРАГ 20-д харуулав. Илгээмж хүлээн авсан тохиолдлууд нь ихэвчлэн өдөр тутмын хэрэглээний зүйлс, тухайлбал хүнсний бүтээгдэхүүн (89.9 хувь), гутал хувцас (23.9 хувь), эм, витамин, гоо сайхны төрлийн бүтээгдэхүүн (11.9 хувь) зэрэг байна.

ЗУРАГ 20. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР*



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Өрхөөс гадаад улсад оршин суугаа шилжигчдэдээ мөнгөн бус илгээмж илгээсэн байдлыг шилжигчдийн оршин суугаа улсаар харуулсан үр дүнг ХҮСНЭГТ 17-д харуулав. Бусад оронд байгаа илгээмж хүлээн авсан шилжигчидтэй харьцуулахад БНСУ, Япон, АНУ зэрэг оронд байгаа илгээмж хүлээн авагчид илүү олон нэр төрлийн өдөр тутмын хэрэглээний эд зүйлсийг Монгол Улс дахь өрхөөсөө хүлээн авдаг болох нь харагдаж байна.


ХҮСНЭГТ 17. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД МӨНГӨН БУС ИЛГЭЭМЖ ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ*, ИЛГЭЭМЖИЙН ТӨРЛӨӨР, ШИЛЖИГЧИЙН ОРШИН СУУГАА УЛСААР

Шилжигчийн оршин суугаа улс	Өрхийн илгээсэн бүтээгдэхүүний төрөл				Илгээмж хүлээн авсан шилжигчдийн тоо
	Хүний бүтээгдэхүүн	Гутал, хувцас	Эм, витамин, гоо сайхны бүтээгдэхүүн	Бусад	
БНСУ	95.0	19.7	15.0	5.7	7 354
Япон	88.1	20.9	9.5	9.4	2576
АНУ	87.1	30.6	7.0	3.5	1 886
ХБНГУ	80.5	37.6	4.0	0.0	628
БНЧУ	92.0	4.0	17.9	0.0	832
Турк	89.1	41.4	0.0	0.0	603
Австри	100.0	0.0	11.6	16.1	207
ШВУ	94.4	11.1	10.9	0.0	602
Австрали	62.5	40.6	7.0	0.0	474
Швейцар	92.1	21.3	40.4	11.0	305
БНХАУ	84.5	0.0	0.0	15.5	155
ИБУИНВУ	85.7	62.7	0.0	0.0	286
Франц	85.0	0.0	41.0	0.0	222
ОХУ	77.8	44.8	0.0	0.0	220
Казахстан	76.3	90.3	0.0	5.7	589
Бусад улс	88.3	10.9	13.5	5.5	1 343
Нийт шилжигчид	89.9	23.9	11.9	5.1	18 282

*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Гадаад улсад амьдарч байгаа гишүүддээ өрхөөс сүүлийн 12 сард мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмж, эсхүл тэдгээрийн аль нэгийг илгээсэн 26373 тохиолдлоос шилжүүлэг илгээхэд нь хүндрэл, бэрхшээл тулгарсан байдлыг асуухад 23.0 хувьд нь тодорхой төрлийн бэрхшээл тулгарсан байна. Гадаад улсад байгаа гишүүддээ гуйвуулга, илгээмж илгээхэд тохиолддог гол бэрхшээлүүд нь шимтгэл өндөр (50.7 хувь), алдагдах эрсдэлтэй, найдваргүй (14.5 хувь), хугацаа урт буую удаж очдог (10.8 хувь) зэрэг байна (ЗУРАГ 21).

ЗУРАГ 21. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ ӨРХ СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН ТОХИОЛДЛУУДЫН ХУВЬ, ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭХЭД БЭРХШЭЭЛ ТУЛГАРСАН БАЙДЛААР



Сүүлийн 12 сарын хугацаанд гадаад улсад оршин суугаа гишүүддээ Монгол Улс дахь өрхүүдийн илгээсэн мөнгөн, мөнгөн бус шилжүүлгийн хэмжээний зарим статистикийг шилжүүлэг илгээсэн өрхийн өгсөн мэдээлэлд суурилсан байдлаар тооцож ХҮСНЭГТ 18-д харуулав.

ХҮСНЭГТ 18. ГАДААДАД ШИЛЖИГЧ ИРГЭДДЭЭ ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭСЭН МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ХҮН АМ, ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРИМ СТАТИСТИК, ШИЛЖҮҮЛГИЙН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, шилжүүлэг илгээгч өрхийн мэдээлэлд суурилсан тооцоогоор.

Гадаад улсад шилжигчдэд шилжүүлэг илгээсэн Монгол Улсын өрх, хүн ам, шилжүүлгийн үзүүлэлтүүд	Шилжүүлгийн төрөл		
	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт
Монгол Улсын өрх, хүн амаас гадаадад байгаа шилжигчдээ илгээсэн шилжүүлгийн нийт дүн (сая төгрөг)	45 242.8	8 897.5	54 140.4
Тухайн шилжүүлэг илгээсэн нэгж өрхөд ногдох жилд илгээсэн шилжүүлгийн дундаж дүн (сая төгрөг)	6.9	0.8	3.5
Тухайн шилжүүлэг илгээсэн өрхийн тоо*	6 584	10 539	15 435
Тухайн шилжүүлэг илгээсэн өрхийн нэг хүнд ногдох жилд илгээсэн шилжүүлгийн дундаж дүн (сая төгрөг)	3.0	0.9	1.5
Тухайн шилжүүлэг илгээсэн өрхүүд дэх хүн амын тоо*	22 164	35 135	51 724
Тухайн шилжүүлэг хүлээн авсан нэгж шилжигчид ногдох жилд хүлээн авсан шилжүүлгийн дундаж дүн (сая төгрөг)	4.0	0.5	2.1
Тухайн шилжүүлэг хүлээн авсан гадаадад оршин сууж буй хүний тоо*	11 376	18 282	26 373

Тайлбар: * мөнгөн ба мөнгөн бус шилжүүлэг аль алиныг илгээсэн бол тоо давхардан тоологдоно.

Судалгааны мэдээлэл цуглуулалтаас өмнөх 12 сарын хугацаанд Монгол Улс дахь шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд 45.2 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулга, 8.9 тэрбум төгрөгтэй дүйцэх эд зүйлсийн илгээмж, нийт дүнгээрээ 54.1 тэрбум төгрөгийн шилжүүлгийг гадаадад шилжсэн иргэддээ илгээсэн гэсэн тооцоо гарлаа. Нэгж өрхөд ногдох илгээсэн дүнг тооцож харвал, шилжүүлэг илгээсэн нэг өрхөөс жилд дунджаар 3,507,571 төгрөг (тэдгээр өрхүүдэд амьдарч буй 1 хүнд ногдох дүнгээр жилд дунджаар 1,467,926 төгрөг)-ийн мөнгө, эд зүйлс шилжигчдийн эдийн засгийг дэмжин гадаад руу илгээгдсэн байна. Эдгээр нь шилжигчдийн гарт очихдоо шилжүүлэг хүлээн авсан нэг шилжигчид дунджаар 2.1 сая төгрөг ногдохуйц дүнтэй байжээ.

Гадаадад шилжигчдэд сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс дахь өрхүүдээс илгээсэн шилжүүлгийн нийт хэмжээг шилжигчдийн одоогийн амьдарч байгаа улсаар задалж тооцсон үр дүнг ХҮСНЭГТ 19-д харуулав.


ХҮСНЭГТ 19. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ МОНГОЛ УЛСЫН ӨРХҮҮДИЙН ИЛГЭЭСЭН ШИЛЖҮҮЛГИЙН НИЙТ ХЭМЖЭЭ, САЯ ТӨГРӨГӨӨР, ШИЛЖҮҮЛГИЙН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 12 САРЫН ДҮНГЭЭР, ШИЛЖИГЧДИЙН ОРШИН СУУГАА УЛСААР

Шилжигчдийн оршин суугаа улс	Өрхүүдийн илгээсэн шилжүүлгийн нийт дүн (сая төгрөг), төрлөөр		
	Мөнгөн гуйвуулга ба илгээмж	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж
БНСУ	21 459.7	16 735.9	4 723.8
Япон	7 027.8	5 842.3	1 185.5
Австрали	6 924.8	6 782.2	142.6
АНУ	3 865.8	2 983.4	882.4
Казахстан	3 499.3	3 208.6	290.7
Турк	2 246.8	2 156.9	89.9
ОХУ	1 576.0	1 512.4	63.6
БНЧУ	654.4	518.3	136.1
Швейцар	383.4	160.7	222.7
Австри	361.8	245.2	116.6
ХБНГУ	332.9	205.0	127.9
ШВУ	226.1	30.3	195.7
БНХАУ	138.8	116.1	22.6
Франц	36.7	1.0	35.7
ИБУИНВУ	32.4	9.4	23.0
Бусад улс	5 373.7	4 735.0	638.7
Нийт	54 140.4	45 242.8	8 897.5

Шилжүүлэг илгээгч өрхийн мэдээлэлд суурилсан тооцоогоор, БНСУ, Япон, Австрали, АНУ, Казахстан зэрэг орнуудад суугаа шилжигчид рүү илгээсэн шилжүүлэг нийт дүнгээрээ Монгол Улсын өрхүүдээс гадагш илгээсэн шилжүүлгийн дийлэнх (79 хувь)-ийг бүрдүүлсэн байна. Гэхдээ шилжүүлэг хүлээн авагч нэг иргэнд ногдох шилжүүлгийн дундаж дүнгээр улс орнуудыг эрэмбэлэхэд Австрали (12.1 сая), Турк (4.5 сая), ОХУ (4.0 сая), БНСУ (3.5 сая), Казахстан (3.0 сая) зэрэг улсад байгаа шилжүүлэг хүлээн авагчид тус бүртээ хамгийн өндөр дундаж дүнтэй шилжүүлгийг хүлээн авч байжээ (ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 8).

Өрхүүдээс өнгөрсөн 12 сарын хугацаанд нэгж шилжигчид илгээсэн гуйвуулга, илгээмжийн дундаж дүн нь хүлээн авсан шилжигчдийн хүн ам зүйн шинжээр ялгаатай байгаа эсэхийг судалсан үр дүнг ЗУРАГ 22-т харуулав. Судалгааны дүнгээр эмэгтэй шилжигчдийн хүлээн авсан шилжүүлгийн дүн эрэгтэйчүүдийнхээс хагас сая төгрөгөөр илүү байна. Түүнчлэн 18-34 настай буюу их, дээд сургуульд суралцах насны, гадаадад очоод удаагүй (6 сараас 1 жил амьдарч буй) шилжүүлэг хүлээн авагчдын өрхөөсөө хүлээн авсан гуйвуулга, илгээмжийн дундаж дүн бусад бүлгийнхнээс өндөр дүнтэй байсан нь харагдлаа.

ЗУРАГ 22. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ СҮҮЛИЙН 12 САРД ШИЛЖҮҮЛЭГ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ИЛГЭЭСЭН ШИЛЖҮҮЛГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ (ТӨГРӨГ), ШИЛЖҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВАГЧИЙН ШИНЖ БАЙДЛААР



Монгол Улс дахь өрхөөсөө мөнгөн гуйвуулга хүлээн авсан шилжигчид уг орлогоо хэрэглээндээ хэрхэн хуваарилсан байдлыг ЗУРАГ 23-т харуулав. Гадаад улсад амьдарч байгаа шилжигчдэд эх орон дахь өрхөөс нь сүүлийн 12 сард илгээгдсэн шилжүүлгийн тохиолдлуудын 40.4 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангахад нь дэм болон зарцуулагдсанаас гадна давхардсан тоогоор 38 хувь нь сургалтын төлбөрт, 12.5 хувь нь байр түрээслэхэд, 2.5 хувь нь гадаад улсад эмчилгээ хийлгэхэд зарцуулагдсан байна.

ЗУРАГ 23. ГАДААДАД ШИЛЖИГЧ ГИШҮҮДДЭЭ СҮҮЛИЙН 12 САРД ӨРХӨӨС ШИЛЖҮҮЛСЭН ШИЛЖҮҮЛГИЙН ТОХИОЛДЛУУД, ХҮЛЭЭН АВАГЧИД НЬ ШИЛЖҮҮЛГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙДЛААР



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

3.4. Гадаадад шилжих хөдөлгөөний өрх, нийгэмд үзүүлж буй нөлөө

Аливаа улсын хүн амын гадаадад шилжих хөдөлгөөн нь гуйвуулга, шилжүүлгээр дамжин шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн эдийн засаг, аж байдалд нөлөө үзүүлэхийн зэрэгцээ нийгэмдээ ч нөлөөлөх боломжтой. Энэхүү бүлэгт Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний өрх болон нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөний талаарх өрхүүдийн санал бодлыг судалсан үр дүнг танилцуулж байна.

Өрхөөс зарим гишүүн гадаад улсад шилжин, ажиллаж амьдарч байгаа нь шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 10.4 хувьд ямар нэг нөлөө үзүүлсэн байна. Давхардсан тоогоор нийт өрхийн 9.1 хувь нь эерэг нөлөө гарсан, 8.4 хувь нь сөрөг нөлөө гарсан гэж үзсэнээс дүгнэвэл, гадаадад шилжин суурьшиж буй иргэдийн ар гэр, хувийн амьдралд нь шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор эерэг болон сөрөг өөрчлөлтүүдийн аль аль нь гарсан байгаа ч эерэг өөрчлөлт, нөлөөг нэрлэсэн өрхүүдийн тоо сөрөг нөлөөг нэрлэсэн өрхүүдээс харьцангуй олон байна. Гадаадад шилжих хөдөлгөөний улмаас өрхийн амьдралд гарсан гэх эерэг нөлөөг ЗУРАГ 24-т, сөрөг нөлөөг ЗУРАГ 25-д тус тус харуулав.

ЗУРАГ 24. ӨРХИЙН ГИШҮҮНЭЭ ГАДААД УЛСАД ИЛГЭЭСНЭЭР АМЬДРАЛД НЬ ЯМАР НЭГ НӨЛӨӨ ГАРСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ЭЕРЭГ НӨЛӨӨГ НЭРЛЭСЭН БАЙДЛААР



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Өрхүүдийн нэрлэсэн эерэг нөлөөг дотор нь 1) өрхийн хүмүүн капиталд гарсан нөлөө, 2) өрхийн амьдардаг ахуй, орчинд гарсан нөлөө гэж ангилж болохоор байна. Өрхөөс зарим гишүүн гадаад улсад явснаар амьдралд нь өөрчлөлт гарсан гэж үзэж буй өрхүүдийн 76 хувь нь өрхийн хүмүүн капиталд эерэг нөлөө гарсан, 62 хувь нь өрхийн ахуйн нөхцөл, амьдрах орчинд эерэг нөлөө гарсан гэж үзэж байна. Хүмүүн капиталд гарсан гэх нөлөөг авч үзвэл, боловсрол, эрүүл мэнд, чөлөөт цаг өнгөрөөх байдалтай холбоотой үр дүнгүүд байсан ба тэднээс боловсролтой холбоотой үр дүн онцгой анхаарал татахаар байна. Тухайлбал, шилжих хөдөлгөөнөөс үр нөлөө мэдэрсэн өрхүүд дунд өрхийн гишүүдийн соёл, мэдлэг боловсрол, ур чадвар зэрэгт ахиц гаргасан байдал ойролцоогоор хоёр өрх тутмын нэгд, хүүхдүүдийнхээ боловсрол, эрүүл мэндэд томоохон хөрөнгө оруулалт хийсэн байдал дөрвөн өрх тутмын нэгд нь тохиолдсон байна.

Хүн амын тогтвор суурьшилтай, сайн сайхан амьдралд аюулгүй, тав тухтай, эрүүл орчинд амьдрах нь чухал нөлөөтэй бөгөөд эдгээр суурь хэрэгцээний асуудалдаа ахиц гаргахад нь шилжих хөдөлгөөн тусалсан хэмээсэн өрхүүд ч багагүй байна. Тухайлбал, шилжих хөдөлгөөний үр нөлөөг мэдэрсэн гэх өрхүүдийн 42.8 хувь нь өрхийн гишүүн гадаад улсад явснаар өрхийн орлого, санхүүгийн байдал дээшилсэн, 6.0 хувь нь өмнөхөөс илүү чанартай хоол хүнс хэрэглэдэг болсон, 5.1 хувь нь орон байрны хуучин нөхцөлөө сайжруулсан, 3.6 хувь нь өрхийн гишүүд эрүүл, агаарын бохирдол багатай орчинд амьдардаг болсон зэргээ шилжих хөдөлгөөний эерэг үр нөлөө гэж үзжээ.

ЗУРАГ 25. ӨРХИЙН ГИШҮҮНЭЭ ГАДААД УЛСАД ИЛГЭЭСНЭЭР АМЬДРАЛД НЬ ЯМАР НЭГ НӨЛӨӨ ГАРСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, СӨРӨГ НӨЛӨӨГ НЭРЛЭСЭН БАЙДЛААР



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Ийнхүү гадаадад шилжих хөдөлгөөн нь илгээгч өрх болон шилжигчдэд чамгүй эерэг нөлөө үзүүлж байгаа ч зарим сөрөг өөрчлөлт, нөлөө мөн үүсгэж буйг өрхүүд мэдээллээ. Тухайлбал, шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэйгээр амьдралд нь өөрчлөлт гарсан гэж үзэж буй өрхүүдийн 61.9 хувь нь гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжилд, 18.7 хувь нь өрхийн гишүүний эрүүл мэнд, өрхийн санхүү зэрэгт, 7.0 хувь нь өрхийн гишүүн төрөлх ахуй соёлоо хадгалж тээх зэрэг асуудалд сөрөг өөрчлөлт мэдэрснээ илэрхийлэв. Тэдгээр дунд анхаарал татаж буй асуудал нь өрхийн гишүүдээ үлдээн шилжиж буй хөдөлгөөний үр дүнд зарим гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжилд сөрөг өөрчлөлт гарсан явдал байв. Тухайлбал, шилжих хөдөлгөөн амьдралд нь нөлөөлсөн гэж үзэж буй өрхүүдийн 43.8 хувь нь өрхийн зарим гишүүд удаан хугацаагаар гэр бүлээсээ хол, тусдаа байснаар гэр бүлийн гишүүдийн амьд харилцаа, харилцан туслах, асрах байдал үгүйлэгддэг, 6.3 хувь нь гэр бүлийн хосуудын харилцаа муудсан, 1.3 хувь нь гэр бүл салсан, улмаар 10.5 хувь нь дээрх харилцаануудын улмаас хүүхдийнх нь хүмүүжилд сөрөг өөрчлөлт гарсан гэсэн мэдээллийг өгсөн байна. Мөн өрхийн гишүүнээ гадаадад явуулах нь зарим өрхийн хувьд санхүүгийн хүндрэл, өрийн дарамт ч үүсгэсэн байна.

Өрхөөс гадаадад шилжсэн гишүүдэд гарсан сөрөг өөрчлөлтийн тухайд, монгол ахуй, соёл, уламжлалаасаа холдож хөндийрөх, эх орондоо буцах сонирхолгүй болох зэргийг өрхүүд нь сөрөг өөрчлөлт гэж дүгнэсэн байна. Мөн шилжигчид гадаадад ажилласнаар, ялангуяа хөдөлмөрийн гэрээгээр дадлагажигчаар ажиллахаар явсан иргэд 3-D төрлийн ажил хөдөлмөр⁷-ийн салбарт түлхүү ажилласнаар эрүүл мэндээрээ хохирсон гэсэн үзэгдэл анхаарал татаж байна.

Шилжих хөдөлгөөнийг амьдралд нь нөлөөлсөн гэж үзэж буй өрхүүдийн 4.3 хувь буюу 258 өрхөд уг асуудал тохиолдсон байгаа нь анхаарахгүй орхиж болохгүй үзүүлэлт гэж үзэж байна. Иймд, гадаадад байгаа, ялангуяа хөдөлмөрийн гэрээгээр буюу дадлагажигчаар ажиллахаар явсан иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр шийдвэр гаргагчид, хэрэгжүүлэгчид анхаарч, цаашдын бодлого, хөтөлбөр боловсруулахдаа эдгээр асуудлуудыг авч үзэх хэрэгтэй юм.

Иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн макро түвшинд буюу Монгол Улсад ямар эерэг, сөрөг үр нөлөө үзүүлж буй талаар өрхүүдийн санал бодлыг асуухад, харьцангуй олон төрлийн асуудлыг нэрлэсэн байна (ЗУРАГ 26).

ЗУРАГ 26. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ИРГЭДИЙН ГАДААДАД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ДҮГНЭСЭН БАЙДЛААР



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Хүн амын гадаадад шилжих хөдөлгөөний улс оронд үзүүлж буй эерэг талыг давхардсан тоогоор өрхүүдийн 44.6 хувь нь “туршлага, ур чадвартай боловсон хүчнийг нэмэгдүүлнэ”, 41.2 хувь нь “олон өрхийн амьжиргааг дээшлүүлсэн”, 7.0 хувь нь “шилжигчдээр дамжин Монгол Улсын бизнес, нийгэм, дэд бүтцийн салбарт шинэлэг санаа, бизнес, үйлчилгээ нэвтэрч байгаа” зэргээр дүгнэсэн байна.

⁷ “3-D” ажил гэдэг нь “Difficult, Dangerous, Dirty” буюу гадаад улс орны төрөлх иргэд нь төдийлөн ажиллах сонирхолгүй байдаг хамгийн “хүнд, аюултай, бохир” хөдөлмөрийн нөхцөлтэй ажлын байруудыг хэлдэг.

Харин гадаадад шилжих хөдөлгөөний сөрөг талыг дүгнэхдээ, давхардсан тоогоор өрхүүдийн 36.1 хувь нь “ур чадвартай боловсон хүчнээ гадагш алдах”, 30.1 хувь нь “Монгол Улсад ажиллах хүчний хомсдол үүсэх” гэсэн байгаа нь хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой асуудлуудыг хөндсөн байв. Эдгээрээс гадна иргэд гадаад руу олноор шилжих нь гэр бүл салалтыг нэмэгдүүлэх (12.4 хувь), хүн амын амын өсөлтийг удаашруулах (12.1 хувь) зэргээр улс орны хүн ам зүйн асуудалд сөрөг нөлөө үзүүлж болохыг дурдсан байна. Түүнчлэн гадаадад шилжин удаан хугацаагаар суурьших иргэдийн дунд эх хэл, соёл уламжлал мартагдах, гадаад улсын соёл, ахуйд уусах зэрэг эрсдэл байгааг өрхүүдийн 24.4 хувь нь сануулсан байна.

3.5. Гадаадад шилжих хөдөлгөөний цаашдын хандлага, төрөөс анхаарах асуудлууд

Энэ хэсэгт гадаадад амьдарч буй иргэдэд хэрэгцээтэй байгаа дэмжлэг, шилжигчдийг эх орондоо буцан ирэх, дасан зохицоход төр засгийн зүгээс шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлуудын талаарх өрхүүдийн санал бодол, түүнчлэн Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний ойрын ирээдүйн хандлагын талаар танилцуулна.

Гадаад улсад оршин суугаа иргэдэд дэмжлэг үзүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлуулахад, шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 51.9 хувь нь шаардлагатай гэж хариулсан байна. Тэдгээр өрхүүдээс хөтөлбөрт ямар асуудлуудыг тусгавал хэрэгцээтэй байгааг асуусан үр дүнг ХҮСНЭГТ 20-д нэгтгэн харуулав.

Гадаадад байгаа иргэдэд шаардлагатай гэх дэмжлэгүүдийг хэр олон өрх нэрлэснээр нь эрэмбэлбэл, нэгдүгээрт, буцах шилжих хөдөлгөөнийг дэмжсэн арга хэмжээ явуулах (25.8 хувь), хоёрдугаарт, гадаадад байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд туслах үйлчилгээ, бүтцийг ажиллуулах (14.0 хувь), гуравдугаарт Виз олголт, сунгалтыг Монгол Улсын иргэдэд ээлтэй болгох талаар ажиллах (13.5 хувь), дөрөвдүгээрт Элчин сайдын яам, консулын газруудын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах (13.1 хувь), тавдугаарт гадаадад суралцагчид боловсролын үйлчилгээ авахад тохиолдож буй санхүүгийн болон бусад асуудлыг шийдэхэд туслах санаачилга, арга хэмжээ хэрэгжүүлэх (12.1 хувь) гэсэн асуудлуудыг хамгийн олон өрх чухалд тооцсон байна.

Буцах шилжих хөдөлгөөнийг дэмжих хүрээнд, гадаадад очсон иргэдэд эх орондоо буцахыг дэмжсэн мэдээлэл түгээх, арга хэмжээ хэрэгжүүлэх, визний хугацаа хэтрүүлэн зөвшөөрөлгүй оршин сууж буй иргэдийг болон бусад санхүүгийн асуудлаас буцахад хүндрэлтэй байгаа иргэдийг буцахад туслах арга хэмжээнүүд санаачлан хэрэгжүүлэх, гадаадаас эх орондоо буцаж ирэгчдэд дасан зохицох, хөлөө олоход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, Монгол Улсад хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулах замаар гадаадад буй иргэдийг буцаан татах нөхцөл бүрдүүлэх зэрэг ажлууд чухал байгааг өрхүүд сануулсан байна.

ХҮСНЭГТ 20. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУСГАЙЛСАН ХӨТӨЛБӨР ШААРДЛАГАТАЙ ГЭСЭН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ХӨТӨЛБӨРТ ТУСГУУЛАХЫГ ХҮСЭЖ БУЙ АСУУДЛЫГ НЭРЛЭСЭН БАЙДЛААР

Хөтөлбөрт тусгуулахыг хүсч буй асуудлууд	Өрхийн хувь (Тоо)
Эх орондоо буцахыг дэмжсэн мэдээлэл түгээх, арга хэмжээ хэрэгжүүлэх; буцахад туслах; буцаж ирэгчдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх; Монгол Улсад иргэдийг татах нөхцөл бүрдүүлэх	25.8% (7759)
Гадаадад байгаа иргэдийг хөдөлмөрт зуучлах болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой иргэдийн зөрчигдсөн эрхүүдийг хамгаалахад туслах үйлчилгээ зохион байгуулах	14.0% (4197)
Виз олголт, сунгалтыг монгол иргэдэд ээлтэй болгох талаар ажиллах (ялангуяа хөдөлмөрийн гэрээний ажилчдын гэр бүлтэйгээ хамт байх боломжийг анхаарах)	13.5% (4067)
Элчин сайдын яам, консулын газруудын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах (иргэдэд мэдээлэл өгөх, хүний эрхийн зөрчлүүдийг шийдэхэд туслах, хүнд сурталгүй ажиллах, иргэдийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах...)	13.1% (3932)
Гадаадад суралцагчид боловсролын үйлчилгээ авахад тохиолдож буй санхүүгийн болон бусад асуудлыг шийдэхэд туслах санаачилга, арга хэмжээ хэрэгжүүлэх	12.1% (3627)
Иргэдийн эрүүл мэндэд зориулсан арга хэмжээнүүд санаачлан хэрэгжүүлэх (хэрхэн үйлчилгээ авах талаар зөвлөгөө хүргэх, урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд визтэй, виз хэтрүүлсэн иргэдээ хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээ авахад тохиолдож буй асуудлуудыг шийдэхэд туслах бүтэц, үйлчилгээ ажиллуулах...)	7.5% (2244)
Визний хугацаа хэтрүүлэн оршин сууж иргэдийн дундах хүний суурь эрхийн зөрчлүүдийг шийдвэрлэхэд туслах үйлчилгээ ажиллуулах	6.0% (1815)
Зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүйгээр гадаадад ажилласан хугацааны нийгмийн ба эрүүл мэндийн даатгалын асуудлыг иргэдэд ээлтэйгээр шийдэх, 2 улсад сонголттойгоор/хослуулсан байдлаар даатгал төлөх боломж бүрдүүлэх	5.7% (1707)
Анх очсон иргэдэд дасан зохицоход туслах үйлчилгээ үзүүлдэг бүтэц ажиллуулах	1.9% (581)
Гадаадад бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүд хэрэгжүүлэх	1.8% (546)
Монгол хэл, соёл уламжлалаа хэрэглэх, сурах, өвлүүлэх, таниулахад чиглэсэн арга хэмжээнүүд явуулах	0.9% (285)
Монгол Улсаас иргэддээ хуваарилдаг баялаг, боломжууд (хувьцаа, хүүхдийн мөнгө, газар хувьчлал, тэтгэвэр г.м)-ыг гадаадад байгаа иргэддээ адил тэгш хүртээх	0.9% (281)
Иргэд бүлгийн зохион байгуулалтаар бие бидээ туслах орчин бүрдүүлж, байгууллага ажиллуулахыг дэмжих	0.6% (166)
Илгээмж, гуйвуулга явуулдаг үйлчилгээнүүдийг боловсронгуй, хямд байлгах талаар ажиллах, хүртээмжийг нэмэгдүүлэх	0.3% (96)
Тодорхой хэлж мэдэхгүй байна	7.9% (2363)
Гадаад улсад амьдарч буй иргэдэд дэмжлэг үзүүлэх тусгайлсан хөтөлбөр шаардлагатай гэсэн өрхүүдийн тоо	30 047

*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Харин гадаадад байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд туслах үйлчилгээ, бүтцийг ажиллуулах хүрээнд нэгэнт гадаадад очсон монгол иргэдийг бүтэн болон хагас цагийн ажлын байруудад хөдөлмөрт зуучлах, визтэй болон визийн хугацаа хэтрүүлсэн хөдөлмөр эрхэлж буй иргэдийнхээ ажил эрхлэлттэй холбоотой эрхийн зөрчлүүд, тухайлбал хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байрны аюултай орчинд ажиллуулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанаас үүдэлтэй өвчлөл, гэмтэл, бэртэлд өртөх, ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл зэргээс хамгаалах, эрхийг сэргээхэд нь туслах бүтэц, үйлчилгээ ажиллуулах хэрэгтэй талаар хөндсөн байна.

Виз олголт, сунгалтыг монгол иргэдэд ээлтэй болгох хүрээнд, монгол иргэдийн хамгийн олноор оршин сууж буй орнуудад хөдөлмөрийн гэрээгээр дадлагажигчаар ажиллахаар явсан иргэдийн визний нөхцөл нь гэр бүлтэйгээ хамт байх боломжгүй байгаа асуудлыг нааштайгаар шийдүүлэх чиглэлээр зохих байгууллагууд ажиллаж өгөхийг хүссэн саналууд ихээхэн дурдагдаж байсан.

Элчин сайдын яам, консулын газрууд үйл ажиллагаагаа иргэдэд ойртуулах хүрээнд, иргэдийн амьдралд чухал нөлөөтэй шийдвэр, мэдээллийг иргэддээ хүртээмжтэй байдлаар хүргэж байх, гадаад улсад иргэн нь хүний эрхийн зөрчилд өртсөн тохиолдлуудад хууль эрх зүйн болон бусад талаас шийдэл олоход нь тусалж байх, хүнд сурталгүй ажиллаж асуудлын шийдлүүдийг түргэн шуурхай гаргаж байх, иргэдийн сайн дурын үндсэн дээр хийгдэх ажлууд, төрийн бус байгууллагуудыг дэмжих үйл ажиллагаанууд зохион байгуулах зэрэг ажлыг хийвэл иргэдэд хэрэгцээтэй байгаа талаар өрхүүд дурдсан байна.

Дээрх саналуудаас гадна гадаадад байгаа асран хамгаалагчаа дагалдан очсон хүүхдүүдийн боловсролын үйлчилгээнд хамрагдах, эх хэл дээрээ суралцах боломжийн асуудал, их дээд сургуульд суралцахаар очсон оюутан залууст нөхцөлтэйгөөр сургалтын болон амьжиргааны зардлын дэмжлэг олгох, боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг шударга болгож олон оюутан залууст хүртээх зэрэг асуудлыг боловсролын сэдвийн хүрээнд хөндсөн байна.

Боловсролоос дутуугүйгээр өрхүүдийн анхаарал хандуулаасай гэсэн өөр нэг асуудал нь гадаадад байгаа иргэдийн эрүүл мэндэд зориулсан бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх (7.5 хувь) тухай санал байв. Энэ хүрээнд, гадаадад очсон иргэдэд шинэ орчиндоо эрүүл мэндийн үйлчилгээ хэрхэн авах талаар зөвлөгөө хүргэх, гадаадад байгаа монгол иргэддээ тусгайлан зориулсан урьдчилан сэргийлэх багц үзлэгийн арга хэмжээг зохион байгуулах, түүнд визтэй, визийн хугацаа хэтрүүлэн оршин сууж буй иргэдээ жигд хамруулахад анхаарах, эрүүл мэндийн үйлчилгээ авахад иргэдэд тохиолдож буй төрөл бүрийн саад, бэрхшээлүүдийг шийдэх, зөвлөхөд нь туслахуйц бүтэц, үйлчилгээ ажиллуулах боломжтой гэж өрхүүд хэлсэн байна.

Гадаадад оршин сууж буй иргэдийн дунд хүний эрхийн зөрчилд өртөх эрсдэл өндөртэй бүлгүүдийн нэг нь визний хугацаа хэтрүүлэн оршин сууж буй иргэд байсан. Эх орондоо ажиллаад олж болох цалин хөлснөөс харьцангуй өндөр орлого олох боломжууд гадаад улс орнуудад байгаагийн зэрэгцээ визний нөхцөлүүд хатуу чанга байдагтай холбоотойгоор зарим иргэд гадаад улс оронд очоод “харлах” буюу визний хугацааг хэтрүүлэн үлдэж, ажиллаж амьдрах оролдлогууд хийж байна. Визний зөрчилтэйгөөр гадаад улс оронд оршин суух нь хууль бус хэдий ч эх орондоо ажиллаж, амьдрах таатай боломжууд нь бүрдээгүйн улмаас гадаад оронд ажиллаж буй тэдгээр иргэдийн хувьд хөдөлмөрийн таатай нөхцөлд ажиллах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг бүхий л асуудалдаа хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгааг өрхүүд мэдээлсэн. Иймд, өрхүүдийн тодорхойлсноор “аргагүй” сонголт хийсэн гэх тэдгээр иргэдэд дор хаяж эрүүл мэндийн асуудал тулгарах, хүчирхийлэлд өртөх зэрэг нэн яаралтай тохиолдлуудад эрх ашгаа хамгаалахад нь дэмжлэг болох үйл ажиллагаануудыг мөн тусгайлан анхаарах нь зүйтэй (6.0 хувь) гэсэн байна.

Монгол Улсаас гадаад улсад очиж ажиллаж буй нэлээд олон иргэдийн хувьд нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах, тэдгээрт үндэслэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын төрөл бүрийн үйлчилгээ авах боломжууд хязгаарлагдсан байна. Тухайлбал, гадаадад ажилласан хугацааны нийгмийн даатгал төлөлт нь ихэвчлэн гадаад улс орны нийгмийн даатгалын санд ордгоос хожим Монгол Улсдаа буцан ирж амьдрах, тэтгэвэр тогтоолгох үед нь үр ашгаа үзүүлж чадахгүй байгааг зарим өрх дурдсан байна. Иймд, гадаадад ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг иргэн өөрсдөө хүсвэл, Монгол Улсын нийгмийн даатгалын санд төлүүлдэг байх, эсхүл 2 оронд хослуулсан байдлаар төлөх боломжтой болгох зэрэг асуудлаар шийдвэр гаргагчид ажил санаачлан хэрэгжүүлээсэй гэж өрхүүдийн 5.7 хувь нь хэлсэн байна.

Дээрх бүх саналуудаас гадна гадаад улсад б, түүнээс дээш сараар оршин суухаар анхлан очсон иргэдэд шинэ орчин нийгэмдээ харилцаанд орох, дасан зохицоход нь туслан чиглүүлэх үйлчилгээ үзүүлдэг бүтэц ажиллуулах, гадаадад бизнес эрхлэх гэж буй иргэдэд шаардлагатай зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулж байх, монгол хэл, соёл, уламжлалаа хэрэглэх, сурах, өвлүүлэх, түгээхэд чиглэсэн арга хэмжээнүүд тогтмол зохион байгуулж байх зэрэг чухал санаануудыг ч өрхүүдийн 4.6 хувь нь ажил болгоосой хэмээн санал болгосон байна.

Өрхөөс гадаад улсад оршин суугч гишүүнийг Монгол Улсад буцаж ирэхэд төр засгаас нэн тэргүүнд шийдвэрлээсэй гэх арга хэмжээний талаарх саналыг өрхүүдээс асуусан үр дүнг ЗУРАГ 27-д харуулав.

ЗУРАГ 27. ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ГАДААД УЛС РУУ ЯВСАН ИРГЭДИЙГ ЭХ ОРОНDOO БУЦАН ИРЭХЭД ТӨР ЗАСГААС НЭН ТЭРГҮҮНД ШИЙДВЭРЛЭЭСЭЙ ГЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛААР



*олон сонголттой асуулт тул хариултын нийлбэр 100%-иас илүү.

Өрхүүдийн хувьд гадаадад шилжигчдийг буцаж ирэхэд төр засгийн зүгээс шийдэж өгөөсэй гэж хүсэж буй асуудлуудын дийлэнх нь эдийн засгийн гэж болох асуудлууд байна. Тухайлбал, гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдийн 65.1 хувь нь шилжигчдийг буцаж ирэхэд ажлын байраар хангах, 29.2 хувь нь улс орны эдийн засгийг тогтвортой байлгах, 24.7 хувь нь бизнес эрхлэх боломжуудыг нэмэгдүүлэх болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлттэй болгож, гаалийн татвар, хураамжийг багасгах, 15.2 хувь нь бизнесийн болон орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох гэсэн ажлуудыг хийгээсэй хэмээн нэрлэсэн байна. Эдгээрээс гадна зарим өрхүүд эрүүл мэнд, боловсрол, бусад нийгмийн үйлчилгээг илүү боловсронгуй болгох (26.5 хувь), улс төрийг тогтвортой байлгах (14.1 хувь) нь ч мөн шилжигчдийг буцаж ирэхэд чухал гэж үзсэн байна.

Дээрх хариултуудаас харахад шилжих хөдөлгөөний илгээгч өрх болон шилжигч иргэдийн судалгааны хариултууд ижил төрлийн асуултууд дээр зарим онцлог ялгаатай байгаа нь харагдаж байна. Тухайлбал шилжигчдийг буцахад нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай гэх асуудлууд нь өрхөөс авсан судалгаагаар илүү эдийн засагтай холбогдсон асуудлууд байгаа бол гадаадад оршин суугч иргэдээс авсан судалгаагаар амьдрах орчин нөхцөлтэй холбогдох асуудлууд илүүтэй дурдагдсан байв.


Гадаадад шилжих хөдөлгөөний цаашдын хандлагыг тандахын тулд шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүдээс ирэх нэг жилийн хугацаанд гадаад улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суухаар явах төлөвлөгөөтэй хүн байгаа эсэхийг асуухад, 14126 өрх буюу дөрвөн өрх тутмын нэг нь “тийм” гэсэн хариултыг өгчээ. Одоогоор гадаадад гишүүнээ илгээсэн байгаа ч нэмж өөр гишүүнээ гадаад улсад явуулахаар төлөвлөж байгаа өрхүүдээс зорилгыг нь асуухад, гурван өрх тутмын нэг нь ажил эрхлэлттэй холбоотой, таван өрх тутмын нэг нь гадаадад байгаа гэр бүлийн гишүүнтэй хамт байх, нэгдэх, мөн таван өрх тутмын нэг нь боловсрол эзэмшихтэй холбоотой зорилгыг нэрлэсэн байна (ЗУРАГ 28). Эдгээрээс гадна гадаад улсад бүрмөсөн суурьших, цагаачлахаар төлөвлөж буй гишүүнтэй өрх 4.5 хувь, өрхийн гишүүн нь гадаадад урт хугацааны эмчилгээ хийлгэхээр төлөвлөж буй өрх 3.7 хувийг эзэлж байв.

ЗУРАГ 28. ИРЭХ 12 САРЫН ХУГАЦААНД ӨРХИЙН ГИШҮҮН НЬ ГАДААД УЛС РУУ 6-ААС ДЭЭШ САРААР ШИЛЖИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ШИЛЖИЛТИЙН ЗОРИЛГООР



Гадаад улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар явахаар төлөвлөж байгаа гишүүнтэй өрхийн шинж байдлыг авч үзвэл (ЗУРАГ 29), өрхийн байршил, орон сууцны зээлтэй эсэх зэргээр онцын ялгаагүй байв. Харин өрхийн ам бүлийн тоо 3-аас олон, бусад өрхүүдээсээ орлогоор харьцангуй өндөр бүлгийн, өрхөөс нь 2 хүн гадаад улсад аль хэдийн оршин сууж буй, гадаад улс дахь өрхийн гишүүдээсээ гуйвуулга, илгээмж хүлээн авч байсан өрхүүд бусдаас илүүтэйгээр ойрын 1 жил дотор өрхийн өөр гишүүнийг гадаад улсад шилжигчээр илгээхээр төлөвлөж байна. Эдгээр үр дүн нь шилжих хөдөлгөөний сэдэл, үргэлжлэх байдлыг тайлбарладаг шилжих хөдөлгөөний онолын тайлбаруудыг баталгаажуулсан үр дүнгүүд байв.

ЗУРАГ 29. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, ИРЭХ 12 САРЫН ХУГАЦААНД ӨРХИЙН ГИШҮҮН НЬ ГАДААД УЛС РУУ 6+ САРААР ШИЛЖИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ЭСЭХЭЭР, ӨРХИЙН ШИНЖ БАЙДЛААР



ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

“Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө” судалгааг гадаадад шилжигч гишүүнтэй Монгол Улсын өрхүүдээс мэдээлэл цуглуулан хийж гүйцэтгэлээ. Судалгааны гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл:

- Монгол Улсын нийт өрхийн 6.1 хувь нь гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрх байгаа ба гадаадад шилжих хөдөлгөөний гол урсгал нь “хот суурин газраас гадаад руу” гэсэн чиглэлтэй явагдаж байна.
- Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхүүд шилжигчдийн эзгүйд дунджаар 3.2 ам бүлтэй, ихэвчлэн хөдөлмөрийн бус насны хүн амаас бүрдсэн байна. Илгээгч өрхийн сарын дундаж орлого нь 1.5 сая төгрөг, орлогын үндсэн эх үүсвэр нь тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс, 10 өрх тутмын 4 нь хөдөлмөр эрхэлдэг хүнгүй байна.
- Монгол Улсын хүн амын 3 хувьтай тэнцэхүйц хэмжээний хүн ам гадаадад шилжигч байгаагаас тал нь 32-оос дээш настай, гадаадад амьдарч байгаа дундаж хугацаа нь 7.2 жил, 10 хүн тутмын 3 нь БНСУ, 2 нь АНУ, Японд, 5 нь бусад улсуудад амьдарч байна. Гадаадад шилжигчдийн 44.3 хувь нь эдийн засгийн, 35.9 хувь нь сурч боловсрох, 13.1 хувь нь гэр бүлийн гишүүдээ дагалдах гэсэн зорилгоор шилжсэн ба 15-34 насны шилжигчид дунд суралцах (79.5 хувь), 35, түүнээс дээш насныхан дунд ажиллах, түүнтэй холбоотой гэр бүлээ даган шилжин суурьших (79.6 хувь) зорилго түгээмэл байна. Гадаадад шилжигч 10 хүн тутмын 4 нь Монгол Улсад байхдаа хөдөлмөр эрхэлж байсны 3 нь цалин хөлстэй хөдөлмөр эрхлэгч байжээ.
- Шилжих хөдөлгөөний илгээгч 10 өрх тутмын 4 нь сүүлийн 12 сарын хугацаанд дунджаар 5.8 сая төгрөгийн хувийн шилжүүлгийг гадаадад шилжигч гишүүнээс хүлээн авсан байна. Нөгөө талаас 10 өрх тутмын 2-3 өрх нь гадаадад шилжигч гишүүндээ сүүлийн 12 сарын хугацаанд дунджаар 3.1 сая төгрөгийн хувийн шилжүүлэг илгээжээ. Гадаадад шилжигч иргэдээс 35-аас дээш насныхан өрхдөө мөнгөн ба мөнгөн бус шилжүүлэг илгээх нь илүү байгаа бол 35-аас доош насныхны хувьд өрхөөсөө шилжүүлэг хүлээн авч байгаа нь илүү байна. Нийт дүнгээрээ сүүлийн 12 сард Монгол Улсын өрхүүдэд доод тал нь 149.0 тэрбум төгрөгийн шилжүүлэг гадаадад шилжигчдээс орж ирж, эсрэгээрээ 54.1 тэрбум төгрөгийн шилжүүлэг гадаадад шилжигчид рүү илгээгдсэн байна.
- Гадаадаас мөнгөн гуйвуулга хүлээн авсан тохиолдлуудын 82.3 хувь нь өрхийн өдөр тутмын хэрэгцээг хангахад дэм болон зарцуулагдсанаас гадна давхардсан тоогоор, 47.3 хувь нь эрүүл мэнд, боловсрол зэрэг хүмүүн капиталд хөрөнгө оруулахад, 11.1 хувь нь өрхийн өр зээлийг барагдуулахад, 4.3 хувь нь байр, сууц, газар зэрэг удаан эдэлгээтэй өмч хөрөнгө худалдан авахад, 3.0 хувь нь хадгалахад, 2.6 хувь нь өрхийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хөрөнгө оруулалт болгон ашиглагдсан байна. Гуйвуулга, илгээмж хүлээн авагч өрхүүдийн дийлэнх (95.8 хувь) гадаадад шилжигчдийн

илгээсэн шилжүүлэг өрхийн амьжиргаанд нь эерэг нөлөө үзүүлсэн хэмээн үзэж байна.

- Өрхөөс гадаадад шилжигчдэд илгээсэн мөнгөн гуйвуулгын тохиолдлууд нь ихэвчлэн шилжигчдийн өдөр тутмын хэрэглээ, сургалтын төлбөр, байрны зардал зэрэгт зориулагдсан байгаа нь Монгол Улсаас гадаадад гарч буй хувийн шилжүүлэг ихэвчлэн боловсрол эзэмших зорилготой шилжигчид рүү чиглэсэн болохыг илтгэж байна.
- Өрхийн гишүүнээ гадаадад илгээсэн нь шилжигчийн болон илгээгч өрхийн гишүүдийн соёл, мэдлэг, ур чадвар, бие даах байдал, орлого санхүүг сайжруулж, хүүхдүүддээ хөрөнгө оруулах байдлыг нэмэгдүүлсэн гол эерэг талтай байгаа ч зарим тохиолдолд сөрөг нөлөөг мөн үзүүлж байна. Тухайлбал, гадаадад шилжих хөдөлгөөнийг дагалдан гэр бүлийн гишүүд тусгаарлагдан гэр бүлээ асрах, халамжлах боломжгүй болох, гэр бүлийн харилцаа муудах, тэр дундаа хүүхдийн хүмүүжил муудах зэрэг сэтгэл зүйн болон гэр бүлийн харилцааны сөрөг нөлөөг зарим өрхөд үүсгэсэн байгааг анхаарах нь зүйтэй.
- Цаашид иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний урсгал үргэлжлэх төлөвтэй байгаа нь шилжих хөдөлгөөний илгээгч 4 өрх тутмаас нэг нь ирэх нэг жилийн хугацаанд дахин өрхийн гишүүдээсээ гадаад улс руу явуулахаар төлөвлөж байгаагаас харагдаж байна.

Судалгааны үр дүнд үндэслэн гадаадад шилжих хөдөлгөөний зохицуулалтын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Гадаадад шилжсэн иргэдийн буцаж ирэхийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх. Үүний тулд:
 - ✓ Нэн тэргүүнд Монгол Улсад иргэдийн нутагтаа амьдрах, ажиллах, суралцах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр буюу иргэн бүрд ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр улам илүү хөрөнгө оруулалтууд хийх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад иргэдийн аюулгүй, эрүүл, хүртээмжтэй амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах нь гадагш чиглэсэн хүн амын урсгалыг буцаан татах гол хүчин зүйл болохыг анхаарах нь зүйтэй.
 - ✓ Суралцах, хөдөлмөр эрхлэх зорилгоор гадаад улсыг зорьж байгаа хүмүүст буцаж шилжин ирэх болзолтойгоор хөдөлмөр эрхлэлтийн, орон сууцны, бизнес эрхлэлтийн, нийгмийн хамгааллын таатай боломжууд олгох ажлуудыг судлан хэрэгжүүлэх нь зүйтэй.
 - ✓ Гадаад улсад ажиллаж буй элчин сайд, консулын газрууд, шилжилт хөдөлгөөний чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаагаар шилжигчдэд буцах сэдэл, хандлага төрүүлэх мэдээ, мэдээлэл, үйл ажиллагаанууд зохион байгуулдаг байх.

2. Гадаадад байгаа иргэдийн мөнгөн гуйвуулга болон мөнгөн бус илгээмж өрхийн болон Монгол Улсын эдийн засагт багагүй хувь нэмэр үзүүлж буй нь харагдсан тул гуйвуулга, илгээмж хүлээн авах одоогийн дэд бүтцийг улам өргөжүүлж, олон төрөл, салбартай болгохын зэрэгцээ өртгийг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагууд ажиллах нь зүйтэй. Ялангуяа монгол иргэд олноор оршин сууж буй зарим орноос Монгол Улс руу илгээх гуйвуулгын өртөг харьцангуй өндөр байгаа талаар иргэд мэдээлснийг анхаарч ажиллах нь зүйтэй болов уу.
3. Гадаадад шилжих хөдөлгөөний ирээдүйн хандлагыг илүү нарийвчлан гаргахын тулд түүврийн хүрээг зөвхөн одоогоор гадаадад шилжсэн гишүүнтэй өрхөөр хязгаарлахгүйгээр өргөн хүрээтэй түүврээс судлах нь зүйтэй. Тухайлбал, гадаадын зарим улс оронд ӨНЭЗС, ХАОСТ зэрэг томоохон судалгаануудаар иргэдийнхээ гадаадад шилжсэн түвшин, түүний ирээдүйн хандлага, хувийн шилжүүлгийн орох, гарах урсгалын асуултуудыг багтаан судалдаг туршлагыг хэрэгжүүлэх боломжтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Батбуян, Б. (2015). Шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн газар зүйн хүчин зүйл. Монгол орны газарзүйн асуудлууд, 262-267.
2. Мөнхжаргал, Б. (2022). Монгол Улсын гадаад шилжилт хөдөлгөөний судалгаан дахь тулгамдсан асуудал: Мэдээллийн эх үүсвэр, чанар. Монголын хүн амын сэтгүүл, дугаар 32, 2022, х.7-20. МХАХН, МУИС-ийн ХАССТ, Улаанбаатар: МУИС Пресс. (<https://journal.num.edu.mn/MJP/article/view/3434>)
3. Мөнхжаргал.Б. (2022). Гадаадад шилжигч монгол иргэдийн илгээсэн гуйвуулгын өрхийн хэрэглээнд үзүүлсэн нөлөө (докторын диссертаци)
4. МХАХН, НХХЯ, НҮБХАС. (2005). Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар. Улаанбаатар, Монгол Улс: Адмон Принтинг.
5. ОУШХБ. (2018). Монгол Улс: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа. ОУШХБ.
6. ҮСХ. (2021). Шилжих хөдөлгөөн, суурьшил (Сэдэвчилсэн судалгаа). Улаанбаатар хот.
7. ҮСХ.(2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, Улаанбаатар хот.
8. ҮСХ.(2021). “Шилжих хөдөлгөөн, суурьшил” Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын сэдэвчилсэн судалгаа
9. ХНХЯ, НҮБХАС, Хүний хөгжил сургалт судалгааны төв. (2016) Монгол улсын гадаад шилжих хөдөлгөөний тоон болон чанарын судалгаа (хэвлэгдээгүй тайлан)
10. OECD. (2000). *Science, Technology and Innovation in the new economy*.
11. Sefer Sener, E. S. (2011). *The effects of science-technology-innovation on competitiveness and economic growth*. *Procedia Social and Behavioral Sciences*, 815-8282.
12. The World Bank. (2020). *Mongolia: Infrastructure for Connectivity and Economic Diversification*. USA.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. Үр дүнгийн хүснэгтүүд

Хүснэгт 1. Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн тоо, сарын дундаж орлого, зарлагын хэмжээ, өрхийн шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Өрхийн тоо	Сарын дундаж орлого, төгрөгөөр	Сарын дундаж зарлага, төгрөгөөр	Зарлагын төрөл, төгрөгөөр	
				хүнсний	хүнсний бус
БҮГД	57,896	1,460,658	1,113,557	596,962	517,392
Байршил					
Хот	52,362	1,488,982	1,138,380	613,429	525,826
Хөдөө	5,534	1,192,676	878,702	441,159	437,595
Өрхийн ам бүлийн тоо					
1-2 гишүүнтэй	24,532	1,179,637	932,046	475,587	457,641
3-4 гишүүнтэй	19,497	1,570,404	1,196,687	638,398	558,317
5, түүнээс олон	13,867	1,803,495	1,317,780	753,420	565,556
Хөдөлмөр эрхэлдэг хүний тоо					
байхгүй	23,755	925,164	823,963	450,776	375,220
1 хүн	20,649	1,511,888	1,168,905	632,723	536,521
2 хүн	11,124	2,128,352	1,494,545	778,484	715,155
3, түүнээс олон	2,368	3,249,305	1,746,309	898,895	847,808
Өрхөөс гадаадад байгаа гишүүдийн тоо					
1 хүн	41,933	1,468,224	1,099,625	593,279	507,299
2 хүн	10,211	1,440,462	1,118,536	584,003	534,447
3, түүнээс олон	5,752	1,441,345	1,206,285	646,815	560,702
Өрхийн сууцны төрөл					
Байшин:					
Орон сууцны байшин	31,832	1,591,029	1,203,842	633,159	570,827
Бие даасан тохилог сууц	1,673	2,001,100	1,285,266	679,333	605,932
Сууцны тусдаа байшин	15,311	1,238,404	985,686	552,108	434,797
Нийтийн байр	323	985,570	887,163	430,380	456,783
Гэр	6,042	1,150,350	891,153	471,839	423,103
Бусад сууц	2,714	1,599,652	1,192,244	673,060	519,184
Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр					
Өөрийн эзэмшлийн	51,494	1,461,351	1,100,616	585,840	515,926
Бусдын сууцанд түрээстэй	2,940	1,596,777	1,360,022	745,266	607,897
Бусдын сууцанд түрээсгүй	2,719	1,209,201	1,062,936	606,094	459,450
Бусад	743	1,794,144	1,220,479	747,564	472,915
Орон сууцны зээлтэй эсэх					
Тийм	7,701	1,846,837	1,280,567	632,983	647,584
Үгүй	50,195	1,401,408	1,087,933	591,435	497,418
Өрхийн орлогын бүлэг					
800,000, түүнээс бага	15,643	-	-	-	-
800,001-1,190,000 төгрөг	13,340	-	-	-	-
1,190,001-2,000,000 төгрөг	20,076	-	-	-	-
2,000,001, түүнээс дээш	8,837	-	-	-	-
Өрхийн зарлагын бүлэг					
600,000, түүнээс бага	15,704	-	-	-	-
600,001-1,000,000 төгрөг	19,998	-	-	-	-
1,000,001-1,400,000 төгрөг	7,832	-	-	-	-
1,400,001, түүнээс дээш	14,362	-	-	-	-

Хүснэгт 2. Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн тоо, орлогын эх үүсвэр, байршлаар, давхардсан тоогоор

Үзүүлэлтүүд	Хот	Хөдөө	Бүгд
ӨРХИЙН ТОО	70,798	7,709	78,506
Орлогын эх үүсвэр			
Цалин хөлс	27,163	2,090	29,252
Тэтгэвэр	29,367	2,881	32,248
Тэтгэмж	4,498	1,063	5,560
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	1,967	956	2,924
ХАА-н салбар болон түрээсийн үйл ажиллагаанаас бусад бизнесийн орлого	1,886	316	2,202
Хувь хүн/өрхөөс ирдэг тусламж, гуйвуулга	1,964	123	2,087
Өмчөө бусдад түрээслүүлсний орлого	126	-	126
Хадгаламжийн хүү, хувьцааны ногдол ашиг	76	-	76
Бусад орлого	3,750	280	4,030

Хүснэгт 3. Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхөд амьдарч байгаа хүн амын тоо, хүйс, насны бүлгээр

Үзүүлэлтүүд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
ХҮН АМЫН ТОО	90,097	90,097	186,321
Насны бүлэг			
0-5	8,160	5,178	13,337
6-11	9,951	8,603	18,555
12-17	11,654	7,233	18,887
18-24	8,466	5,671	14,137
25-49	23,677	23,820	47,496
50-59	16,131	17,700	33,831
60, түүнээс дээш	18,185	21,893	40,078

Хүснэгт 4. Гадаадад шилжигчдийн тоо, шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Бүгд		Хүйс					Оршин суугаа хугацаа, жилээр					Оршин суугаа зорилго						
	49,139	57,395	Эрэгтэй		Эмэгтэй			10,217	42,631	30,496	11, түүнээс дээш жил	35,899	35,346	11,360	Албан томилолтоор ажиллах	141	17,688	3,538	2,562
			Эрэгтэй	Эмэгтэй	6-10 жил	2-5 жил	Суралцах												
ХҮН АМЫН ТОО	106,534	49,139	57,395	10,217	42,631	30,496	23,190	35,899	35,346	11,360	141	17,688	3,538	2,562					
Насны бүлэг																			
0-4	3,543	1,967	1,576	1,022	2,522	-	-	-	-	-	-	3,412	-	131					
5-9	3,999	1,897	2,102	197	1,566	2,236	-	-	-	-	-	3,328	-	671					
10-14	4,679	1,958	2,721	-	1,492	1,340	1,848	-	-	-	-	4,381	-	298					
15-19	6,250	3,738	2,512	2,486	1,874	1,115	775	4,392	89	89	-	1,680	-	-					
20-24	9,916	5,242	4,675	1,690	6,884	1,050	293	8,347	882	469	-	217	-	-					
25-29	14,531	7,626	6,904	1,495	8,808	3,684	543	8,360	3,332	2,207	74	267	242	49					
30-34	18,974	9,565	9,409	1,138	8,298	7,431	2,107	7,424	6,495	3,516	34	1,103	268	134					
35-39	12,945	5,705	7,240	636	4,182	4,818	3,310	3,711	5,923	1,573	33	802	601	301					
40-44	11,930	4,670	7,260	565	3,337	3,543	4,485	2,226	6,573	1,798	-	645	445	242					
45-49	7,708	2,691	5,017	278	1,726	2,380	3,324	608	4,756	1,088	-	648	446	162					
50-54	6,613	2,218	4,395	210	1,208	1,912	3,283	499	4,412	546	-	489	504	163					
55-59	3,004	1,038	1,966	152	536	630	1,686	268	1,738	-	-	441	347	210					
60, түүнээс дээш	2,442	824	1,618	347	200	358	1,537	63	1,146	74	-	274	685	200					
Оршин суугаа улс																			
Солонгос	32,742	15,979	16,762	3,808	15,336	9,457	4,141	11,007	12,762	3,629	-	4,192	309	843					
Америк	13,110	5,590	7,520	536	2,731	4,489	5,354	4,312	4,578	294	-	2,720	1,067	138					
Япон	10,548	5,368	5,181	1,338	5,648	2,543	1,019	4,978	2,306	1,986	-	991	74	213					
Казахстан	4,760	2,450	2,310	795	2,145	937	883	1,935	1,949	122	-	449	242	63					
Чех	7,402	3,409	3,994	626	2,823	1,940	2,013	266	2,802	2,811	24	1,179	57	263					
Австрали	4,119	1,961	2,158	984	1,768	1,114	254	2,306	744	125	33	730	181	-					
Хятад	1,222	455	768	114	697	237	174	745	255	24	-	74	91	34					
Герман	4,159	1,225	2,935	180	1,112	1,062	1,806	1,743	1,184	172	-	715	257	89					
Швед	6,072	2,724	3,348	-	2,611	2,059	1,402	501	2,370	459	-	2,223	168	351					
Франц	2,000	870	1,130	82	311	966	642	478	622	141	-	343	336	81					
Орос	1,863	1,211	652	113	1,031	542	177	1,355	245	40	-	120	104	-					
Турк	3,891	1,512	2,379	430	2,081	1,166	214	1,078	1,917	25	-	871	-	-					
Австри	1,534	261	1,274	-	416	511	608	665	630	33	-	81	67	58					
Швейцар	2,431	784	1,646	49	188	896	1,298	443	843	66	-	874	33	172					
Англи	1,484	528	956	-	274	358	851	443	400	-	-	536	105	-					
Бусад улс	9,196	4,813	4,383	1,163	3,458	2,220	2,355	3,646	1,740	1,434	83	1,588	448	257					

Үзүүлэлтүүд	Бүгд		Хүйс		Оршин суугаа хугацаа, жилээр						Оршин суугаа зорилго						
			Эрэгтэй		Эмэгтэй		1 жил	2-5 жил	6-10 жил	11, түүнээс дээш жил	Суралцах	Хувиараа ажиллах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Гар бусад аргаар	Сурьшиж, чааа члах	Бусад
			Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй											
Гадаад улс руу явахаасаа өмнө хөдөлмөр эрхэлж байсан эсэх																	
Тийм	40,917	18,417	22,500	3,018	16,681	11,934	9,284	8,246	20,986	6,521	141	2,379	1,737	906			
Үгүй, суралцаж байсан	38,182	17,566	20,617	4,197	15,544	10,355	8,086	24,167	8,309	3,022	-	1,676	895	114			
Үгүй, ажилгүй байсан	10,027	4,500	5,528	928	3,337	3,383	2,379	1,893	5,002	1,509	-	861	491	271			
Үгүй, 15 нас хүрээгүй байсан	1,546	1,150	396	-	381	501	664	701	204	-	-	533	108	-			
Үгүй, бусад	2,986	1,239	1,746	677	916	569	825	892	844	308	-	463	308	171			

Хүснэгт 5. Гадаадад шилжигчдээс сүүлийн 12 сард илгээсэн шилжүүлгийн хэмжээ, өрхийн шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Гадаадад шилжигчдээс шилжүүлэг хүлээн авсан өрхийн тоо	Хүлээн авсан шилжүүлгийн нийт хэмжээ, мянган төгрөгөөр			1 өрхийн хүлээн авсан шилжүүлгийн дундаж хэмжээ, мянган төгрөгөөр		
		Нийт	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж
БҮГД	22,622	149,024,854.9	124,223,177.6	24,801,677.3	6,587.7	6,015.2	2,516.9
Байршил							
Хот	20,354	136,141,541.7	113,014,398.3	23,127,143.3	6,688.7	6,073.6	2,562.0
Хөдөө	2,268	12,883,313.2	11,208,779.2	1,674,534.0	5,680.8	5,482.9	2,025.0
Өрхийн ам бүлийн тоо							
1-2 гишүүнтэй	10,063	52,819,695.1	44,754,279.8	8,065,415.3	5,248.8	4,844.9	1,809.9
3-4 гишүүнтэй	7,761	66,012,881.0	54,705,847.4	11,307,033.6	8,505.3	7,835.5	3,354.4
5, түүнээс олон	4,797	30,192,278.7	24,763,050.4	5,429,228.3	6,293.8	5,586.9	2,678.9
Хөдөлмөр эрхэлдэг хүний тоо							
байхгүй	10,159	66,514,149.9	59,536,347.9	6,977,802.0	6,547.3	6,167.7	1,778.4
1 хүн	8,219	59,698,066.6	49,713,078.0	9,984,988.6	7,263.7	6,872.3	2,512.5
2 хүн	3,629	20,660,157.8	13,421,793.1	7,238,364.8	5,693.0	4,205.5	4,607.2
3, түүнээс олон	615	2,152,480.5	1,551,958.6	600,521.9	3,499.8	2,706.7	1,559.6
Өрхөөс гадаадад байгаа гишүүдийн тоо							
1 хүн	15,589	86,223,041.6	74,222,927.8	12,000,113.8	5,530.9	5,290.4	1,956.9
2 хүн	5,069	50,083,225.0	43,355,722.6	6,727,502.4	9,880.3	8,936.0	2,456.0
3, түүнээс олон	1,963	12,718,588.3	6,644,527.2	6,074,061.1	6,477.6	3,753.5	6,183.5
Өрхийн орлогын бүлэг							
800,000, түүнээс бага	6,351	37,544,481.4	34,767,231.5	2,777,249.9	5,911.3	5,634.5	1,447.4
800,001-1,190,000 төгрөг	5,735	37,535,914.5	33,814,292.4	3,721,622.1	6,545.5	6,133.6	1,756.3
1,190,001-2,000,000 төгрөг	7,827	56,243,914.4	41,420,018.1	14,823,896.3	7,186.1	6,054.3	3,488.3
2,000,001, түүнээс дээш	2,709	17,700,544.6	14,221,635.7	3,478,909.0	6,533.6	6,686.9	2,220.8
Өрхийн зарлагын бүлэг							
600,000, түүнээс бага	6,541	40,863,692.8	36,754,446.4	4,109,246.4	6,247.3	5,894.5	1,981.6
600,001-1,000,000 төгрөг	7,616	51,973,279.2	42,285,790.6	9,687,488.7	6,824.3	5,968.3	2,996.7
1,000,001-1,400,000 төгрөг	2,803	13,272,466.5	11,102,528.6	2,169,937.9	4,734.4	4,470.8	1,795.3
1,400,001, түүнээс дээш	5,661	42,915,416.4	34,080,412.1	8,835,004.3	7,580.3	7,030.0	2,646.2

Хүснэгт 6. Өрхийн гадаадад шилжигчдээс сүүлийн 12 сард хүлээн шилжүүлгийн хэмжээ, шилжигчдийн шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Өрхөд шилжүүлэг илгээсэн гадаадад шилжигчдийн тоо	1 шилжигчийн өрхдөө илгээсэн шилжүүлгийн дундаж хэмжээ, мянган төгрөгөөр		
		Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт
Хүйс				
Эрэгтэй	16,839	6,056.2	2,481.1	6,403.9
Эмэгтэй	21,893	5,292.2	2,129.3	5,674.4
Насны бүлэг				
18-34	16,739	5,078.6	1,791.2	5,140.1
35-49	17,063	5,552.5	2,715.5	6,241.1
50, түүнээс дээш	4,929	7,693.0	2,115.2	8,019.4
Гадаад улсад оршин суугаа хугацаа				
1 жил	1,971	3,656.0	1,446.4	3,555.3
2-5 жил	15,823	6,626.1	2,184.2	6,833.4
6-10 жил	11,414	6,169.4	2,719.2	6,734.3
11, түүнээс дээш жил	9,524	3,753.6	1,886.1	4,207.0
Амьдарч байгаа улс				
Солонгос	14,704	6,883.7	3,047.0	7,626.6
Америк	4,754	4,134.4	1,633.4	4,493.4
Япон	4,391	6,868.4	2,979.3	7,272.1
Казахстан	505	6,213.6	5,000.0	6,133.4
Чех	2,266	3,652.6	1,325.8	3,634.6
Австрали	1,418	6,654.7	2,440.3	6,962.2
Хятад	485	7,719.7	608.1	6,937.3
Герман	1,804	4,712.7	1,133.1	4,542.2
Швед	1,556	2,223.4	1,047.5	2,240.2
Франц	737	3,318.4	686.3	3,258.3
Орос	97	4,155.0	224.6	3,276.2
Турк	1,075	2,917.6	1,055.1	3,043.7
Австри	798	5,841.0	2,723.0	6,919.1
Швейцар	811	6,689.6	1,455.1	6,911.5
Англи	313	8,741.1	4,255.1	9,167.2
Бусад улс	3,017	3,462.9	832.3	3,444.9

Хүснэгт 7. Өрхөөс гадаадад шилжигчдэдээ сүүлийн 12 сард илгээсэн шилжүүлгийн хэмжээ, өрхийн шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Гадаадад шилжигчдэд шилжүүлэг илгээсэн өрхийн тоо	Шилжүүлгийн нийт хэмжээ, сая төгрөгөөр			1 өрхийн шилжүүлгийн дундаж хэмжээ, мянган төгрөгөөр		
		Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт	Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт
БҮГД	15,435	45,242.8	8,897.5	54,140.4	6,871.9	844.2	3,507.6
Байршил							
Хот	13,515	39,331.7	8,044.2	47,375.9	6,999.8	865.1	3,505.4
Хөдөө	1,920	5,911.2	853.3	6,764.5	6,127.3	687.6	3,523.0
Өрхийн ам бүлийн тоо							
1-2 гишүүнтэй	5,809	15,594.8	2,772.4	18,367.3	7,659.3	654.5	3,161.9
3-4 гишүүнтэй	5,852	21,213.0	4,852.5	26,065.5	6,727.6	1,353.1	4,454.1
5, түүнээс олон	3,774	8,435.0	1,272.6	9,707.6	6,048.8	468.4	2,572.0
Хөдөлмөр эрхэлдэг хүний тоо							
байхгүй	4,868	4,134.9	1,829.7	5,964.6	3,359.2	477.3	1,225.3
1 хүн	5,779	24,017.8	2,133.6	26,151.4	8,671.3	573.9	4,525.5
2 хүн	3,775	15,885.5	4,622.2	20,507.8	7,217.2	2,074.2	5,433.0
3, түүнээс олон	1,014	1,204.7	311.9	1,516.6	3,154.4	410.5	1,495.4
Өрхөөс гадаадад байгаа гишүүдийн тоо							
1 хүн	10,579	32,358.8	3,762.6	36,121.3	6,586.2	547.1	3,414.6
2 хүн	3,685	11,992.6	1,797.8	13,790.5	9,126.4	668.6	3,742.2
3, түүнээс олон	1,172	891.4	3,337.1	4,228.5	2,500.0	3,427.7	3,609.3
Өрхийн орлогын бүлэг							
800,000, түүнээс бага	2,945	3,650.4	968.6	4,619.0	3,947.5	454.0	1,568.3
800,001-1,190,000 төгрөг	3,182	10,811.2	1,089.5	11,900.7	9,368.5	485.0	3,740.3
1,190,001-2,000,000 төгрөг	5,979	18,704.3	5,230.8	23,935.1	7,176.0	1,276.1	4,003.0
2,000,001, түүнээс дээш	3,329	12,076.9	1,608.6	13,685.5	6,361.3	780.7	4,110.9
Өрхийн зарлагын бүлэг							
600,000, түүнээс бага	3,322	6,061.0	1,149.9	7,210.8	4,720.7	524.1	2,170.6
600,001-1,000,000 төгрөг	5,320	14,177.7	4,809.9	18,987.5	7,174.8	1,198.9	3,569.2
1,000,001-1,400,000 төгрөг	1,926	4,109.0	624.5	4,733.5	4,654.0	537.4	2,458.3
1,400,001, түүнээс дээш	4,868	20,895.2	2,313.3	23,208.5	8,560.7	729.5	4,767.7

Хүснэгт 8. Өрхөөс гадаадад шилжигчдэдээ сүүлийн 12 сард илгээсэн шилжүүлгийн хэмжээ, шилжигчдийн шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Өрхөөс шилжүүлэг хүлээн авсан гадаадад шилжигчдийн тоо	1 шилжигчийн хүлээн авсан шилжүүлгийн дундаж хэмжээ, мянган төгрөгөөр		
		Мөнгөн гуйвуулга	Мөнгөн бус илгээмж	Нийт
Хүйс				
Эрэгтэй	7,467	4,501.0	684.3	2,187.8
Эмэгтэй	9,938	8,032.3	773.7	3,804.0
Насны бүлэг				
0-17	1,394	2,634.9	743.4	1,436.8
18-34	11,099	7,147.2	583.5	4,239.8
35-49	3,704	2,354.4	1,131.0	1,228.9
50, түүнээс дээш	1,207	663.8	412.8	435.6
Гадаад улсад оршин суугаа хугацаа				
1 жил	1,440	6,360.7	358.6	3,960.9
2-5 жил	9,369	6,654.1	596.1	3,627.1
6-10 жил	4,329	6,509.7	1,250.2	3,001.1
11, түүнээс дээш жил	2,267	3,803.1	512.6	645.3
Амьдарч байгаа улс				
Солонгос	6,068	7,574.6	1,084.4	3,536.7
Америк	2,320	6,259.1	457.3	1,666.5
Япон	2,565	6,077.9	629.1	2,740.1
Казахстан	1,157	3,704.7	671.8	3,023.2
Чех	532	2,815.8	366.7	1,229.7
Австрали	570	25,388.6	463.8	12,148.3
Хятад	108	2,050.3	363.5	1,289.0
Герман	397	1,686.5	407.4	838.6
Швед	500	2,458.9	395.7	451.7
Франц	65	100.0	646.8	563.9
Орос	394	3,999.0	891.2	3,996.9
Турк	496	5,174.7	699.5	4,525.7
Австри	183	6,389.4	804.2	1,973.7
Швейцар	423	6,000.0	562.2	906.6
Англи	72	1,600.0	346.9	448.5
Бусад улс	1,553	5,413.4	613.0	3,459.6

Хүснэгт 9. Гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийн нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудалд хариулсан байдал, өрхийн шинж байдлаар

Үзүүлэлтүүд	Ажлын байраар хангах	Эдийн засаг тогтвортой байх	Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг сайжруулах	Бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх	Улс төр тогтвортой байх	Хөнгөлөлт-тэй зээл, тусламж үзүүлэх	Гаалийн татвар, хураамжийг бууруулах	Тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлтөөр авах боломжоор хангах	Бусад
ӨРХИЙН ТОО	37,681	16,923	15,349	11,397	8,153	8,815	1,914	990	8,229
Байршил									
Хот	33,806	15,486	14,503	10,564	7,676	8,260	1,618	902	7,630
Хөдөө	3,876	1,437	845	833	476	555	295	88	599
Өрхийн ам бүлийн тоо									
1-2 гишүүнтэй	16,529	8,193	6,348	4,928	4,322	3,138	548	326	4,160
3-4 гишүүнтэй	12,835	5,688	5,033	3,650	2,484	2,873	792	273	2,796
5, түүнээс олон	8,317	3,041	3,967	2,818	1,346	2,805	574	391	1,274
Өрхөөс гадаадад байгаа гишүүдийн тоо									
1 хүн	27,411	12,165	10,795	8,464	5,348	6,067	1,433	751	5,716
2 хүн	6,436	2,791	2,802	1,560	1,681	1,413	411	234	1,804
3, түүнээс олон	3,835	1,967	1,752	1,373	1,123	1,334	70	5	709
Хөдөлмөр эрхэлдэг хүний тоо									
байхгүй	16,001	7,261	5,941	4,436	3,256	2,960	440	324	3,317
1 хүн	13,271	6,057	5,041	4,125	3,158	3,819	739	380	3,228
2 хүн	6,733	3,120	3,567	2,576	1,396	1,738	479	244	1,319
3, түүнээс олон	1,677	485	799	260	343	297	256	42	364
Орлогын бүлэг									
800,000, түүнээс бага	10,527	3,953	3,789	2,882	1,678	2,142	232	218	2,486
800,001-1,190,000 төгрөг	8,883	4,067	2,896	2,308	2,075	1,673	491	307	1,722
1,190,001-2,000,000 төгрөг	12,695	6,381	5,326	4,276	2,954	3,702	833	427	2,945
2,000,001, түүнээс дээш	5,576	2,522	3,337	1,930	1,446	1,298	357	38	1,077
Зарлагын бүлэг									
600,000, түүнээс бага	10,527	3,953	3,789	2,882	1,678	2,142	232	218	2,486
600,001-1,000,000 төгрөг	8,883	4,067	2,896	2,308	2,075	1,673	491	307	1,722
1,000,001-1,400,000 төгрөг	12,695	6,381	5,326	4,276	2,954	3,702	833	427	2,945
1,400,001, түүнээс дээш	5,576	2,522	3,337	1,930	1,446	1,298	357	38	1,077

Үзүүлэлтүүд	Ажлын байраар хангах	Эдийн засаг тогтвортой байх	Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг сайжруулах	Бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх	Улс төр тогтвортой байх	Хөнгөлөлт-тэй зээл, тусламж үзүүлэх	Гаалийн татвар, хураамжийг бууруулах	Тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлтөөр авах боломжоор хангах	Бусад
Өрхийн сууцны төрөл									
Байшин									
Орон сууцны байшин	20,356	8,723	9,700	6,187	3,960	5,011	1,058	331	5,893
Бие даасан тохилог сууц	1,164	548	589	459	201	155	6	7	271
